

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

### **Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл шаардлага.**

Монгол Улсад Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг анх 1992 онд батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар зохицуулж байсан нь Улсын Их Хурлын сонгуулийн харилцааны эрх зүйн үндсийг тавьсан бөгөөд 2005, 2011 онуудад батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиуд нь тухайн цаг үеийн нийгэм, эдийн засгийн болоод сонгууль зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан Улсын Их Хурлын сонгуулийн харилцааг зохицуулж ирсэн.

2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулиар өмнө нь тус тус бие даасан хуулиар зохицуулагдаж байсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн сонгуулийг зохион байгуулж явуулах журмыг хамтад нь нэг хуулиар зохицуулсан. Уг хуульд 2016 онд 4 удаа, 2017 онд 2 удаа нийт 6 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Сонгуулийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг тус тус зохион байгуулж явуулсан. Эдгээр сонгуулийг зохион байгуулж явуулах явцад Сонгуулийн тухай хуулийг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх тухайд буюу хууль хэрэглээний олон төрлийн хүндрэл үүсэж байсныг сонгууль зохион байгуулж явуулсан бүх шатны сонгуулийн байгууллага, сонгогч, нэр дэвшигч, сонгуульд оролцсон нам, эвслээс илэрхийлж байсан болно.

Улсын Их Хурлын сонгууль, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь тус тусын зохион байгуулалтын онцлог шинж чанартай, процесс үйл ажиллагаа бөгөөд ялангуяа сонгуулийн зохион байгуулалтын бүхий л үйл ажиллагаа нь тухайн сонгуулийн онцлогт тохирсон хуулийн зохицуулалттай байх шаардлагатай байдаг.

Гэтэл эдгээр онцлог бүхий сонгуулийн харилцааг нэг хуулиар зохицуулсан нь хууль хэрэглээний хувьд хүндрэл үүсгэж, улмаар сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг сонгуулийн харилцаанд оролцогчид өөр өөрийнхөө тайлбарлаж хэрэглэх, үүнээс үүдэн сонгуульд оролцогч талуудын хооронд маргаан үүсэх, иргэд сонгогчдод ойлгомжгүй байдал үүсэх зэрэг олон хүндрэлтэй нөхцөл байдалд хүргэж байсан.

Ийм учраас Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулах шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох, тусгайлсан хууль боловсруулах, Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах, түүнчлэн Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах зэргээр Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж боловсронгуй болгох шаардлага байна гэж үзэж байна. Энэ хуулийн төслийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Сонгуулийн тухай хуулийн ерөнхий зарчмыг баримтлан Улсын Их Хурлын сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан бие даасан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг боловсруулсан.

Төслийг боловсруулахдаа ЕАБХАБ-аас 2016, 2017 оны сонгуулиудыг ажиглаад өгсөн зөвлөмж, Сонгуулийн Ерөнхий Хороо болон Улсын дээд шүүхэд бүртгэлтэй нийт улс төрийн намууд, 8 төрийн бус байгууллага, Батлан хамгаалах яам, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, Хил хамгаалах ерөнхий газар, харилцаа холбоо зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх

газар, Үндэсний аудитын газар, Гадаадын иргэн харьяатын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Улсын дээд шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг төрийн болон төрийн бус байгууллага иргэдээс нээлттэй санал авч боловсруулна.

Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог Монгол улсын тогтвортой хөгжлийг хангах, улс орны эдийн засгийн болон нийгмийн хөгжилд эергээр нөлөөлөх байдлыг үндсэн шалгуур болгон тодорхойлж тусгана.

Сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын ил тод байдал, түүнийг хариуцлагатайгаар тайлагнадаг, тайланг хүлээн авсан төрийн байгууллага ил тод мэдээлдэг, нягтлан шалгах үйл ажиллагаанд төрийн бусад байгууллагын чиг үүргийг нарийвчлан тодорхойлж тусгана.

### **Хоёр. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, ерөнхий бүтэц.**

Хуулийн төслийг Улсын Их Хурлын сонгуулийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзэж Хууль тогтоомжийн тухай тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасны дагуу анхдагч хуулийн төсөл боловсруулсан бөгөөд Сонгуулийн тухай хуулийн Улсын Их Хурлын сонгуулийн харилцааг зохицуулж байгаа зохицуулалтуудаас гадна дараах онцлог бүхий нэмэлт зохицуулалтуудыг тусгасан. Үүнд:

1\ Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж, нэр томъёо, сонгуулийн үндсэн зарчим, сонгууль товлон зарлах, сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаатай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд дараах онцлог өөрчлөлтүүдийг тусгасан.

- Улсын Их Хурал ээлжит сонгуулийг товлон зарлах болон санал авах өдрийг хамтад нь тогтоохоор тусгасан,

- Сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд оролцдог төрийн байгууллагуудын сонгуулийн үйл ажиллагаатай холбогдон гарах улсын төсвөөс санхүүжих зардлаа тухайн жилийн төсөвтөө тусган батлуулдаг байхаар тусгасан,

- Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлээс гадна төлөвлөлт, зарцуулалтад аудитын байгууллага хяналт тавьж, дүгнэлт гаргана,

2\ Хуулийн төслийн Хоёрдугаарт бүлэгт Сонгуулийн нутаг дэвсгэрийн хуваарь, сонгуулийн тойрог, хэсэг түүнийг байгуулахтай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд дараах онцлог өөрчлөлтүүдийг тусгасан.

- Нэг хэсэгт байх сонгогчийн доод хязгаарыг тогтоосон,

- Сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах ажиллагаа дуустал засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийн бүтэц, нэр, дугаарт өөрчлөлт оруулахыг хориглосон,

3\ Хуулийн төслийг гуравдугаар бүлэгт сонгуулийн байгууллагын эрх зүйн байдал, бүрэн эрх, ажлын зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд сонгуулийн хэсэгт санал авах тоолох ажиллагааг эрхлэн зохион байгуулах чиг үүрэг бүхий санал авах байрыг байгуулж байсан нь нэр томъёоны хувьд давхцал үүсгэж байсныг өөрчлөн сонгуулийн хэсгийн хороод ажиллахаар тусгасан.

4\ Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол шийдвэрлэх журам, харьяалал, сонгогч шилжихтэй холбоотой харилцааг зохицуулах бөгөөд дараах онцлог зохицуулалтыг тусгасан.

- Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжилсэн ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалтыг нэмж тусгасан,

- Итгэмжлэгдсэн ажилтан нь иргэний бүртгэлийн холбогдох байгууллагын сургалтад хамрагдсан төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч байхаар тусгасан,

5\ Хуулийн төслийн Тавдугаар болон Зургаадугаар бүлэгт Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх нийтлэг журам, нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх, нэр дэвшигч болон нам, эвслийг бүртгэх, бүртгэхээс татгалзах үндэслэл, намын сонгууль эрхэлсэн байгууллагын эрх зүйн байдал, нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаатай холбоотой харилцааг зохицуулсан.

- Сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын Дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй байхаар тусгасан,

- Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэхдээ ээлжит сонгуулийн өмнөх жилийн дөрөвдүгээр сарын нэгний өдрөөс ээлжит сонгуулийн жилийн дөрөвдүгээр сарын нэгний өдрийг хүртэлх хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайланг ирүүлэхээр тусгасан,

- Нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал Засгийн газраас байгуулсан хамтын удирдлагын байгууллагын орон тооны болон орон тооны бус гишүүн ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөх, дахин сонгуулийн тухайд энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн байхаар тусгасан,

6\ Хуулийн төслийн Долоодугаар бүлэгт Сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаатай холбоотой харилцааг зохицуулсан.

- Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны тоог үйл ажиллагааных нь цар хүрээтэй уялдуулан тогтоосон.

- Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг төрийн аудитын байгууллагад хянуулах хугацаа, журмыг тодорхойлсон.

- Сонгуулийн сурталчилгаа явуулах арга хэлбэрийг сонгуулийн зардал багасгах зорилготой уялдуулан тогтоох,

7\ Хуулийн төслийн Наймдугаар бүлэгт сонгуулийн зардал, зардлын дээд хэмжээг тогтоох, сонгуулийн зардлын зарцуулалт, түүнд тавигдах хяналт, тайлан гаргахтай холбоотой харилцааг зохицуулна.

- Сонгуулийн зардлын гүйцэтгэлт тавигдах хяналтыг илүү сайжруулах, үр дүнтэй болгох талаар төрийн аудитын байгууллагын эрх хэмжээг нэмэгдүүлэх,

- Зардлын тайланг түүнд хяналт тавих, нийтэд мэдээлэх эрх бүхий төрийн аудитын байгууллагад шууд хүргүүлдэг болох,

- Хандивлагч нь хуульд заасан шаардлага хангаж буй эсэхээ өөрөө нотлох үүргийг хуульчлах,

- Зардлын тайланг нийтэд мэдээлэх, хандивлагчдын мэдээллийг Татварын байгууллагад хүргүүлж улмаар хандивлагч хуулийн этгээд татварын тайландаа тусгасан эсэхэд хяналт тавих зохицуулалтыг тусгах,

8\ Хуулийн төслийн Есдүгээр бүлэгт саналын хуудас түүнд тавигдах шаардлага, хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалахтай холбоотой харилцаа, санал авах байр хугацаа, зөөврийн болон санал авах байранд санал авах ажиллагаа, сонгуулийн ажиглах, санал хураалтын дүнг гаргах зэрэг үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

- Саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх үйл ажиллагааны хамгаалалтыг цагдаагийн байгууллага, төрийн тусгай хамгаалалтын

асуудал эрхэлсэн байгууллага хариуцах бөгөөд тагнуулын асуудал эрхэлсэн байгууллага хяналт тавьж ажиллах зохицуулалтыг тусгах,

- Саналын хуудас нь санал авах өдөр хүртэл, санал авч эхэлснээс хойш санал тоолж дуусах хүртэл, санал авах ажиллагаа дууссанаас хойш холбогдох журмын дагуу аймаг, нийслэлийн архивд хүлээлгэн өгөх хүртэл цагдаагийн байгууллагын хамгаалалт, тагнуулын байгууллагын хяналтад байх зохицуулалтыг тусгах,
- Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд оролцогч мэдээллийн технологийн багийн бүрэлдэхүүн, даамал нь төрийн захиргааны болон үйлчилгээний алба хаагчдаас бүрдүүлэх,

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болон нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.**

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах эрх зүйн орчин боловсронгуй болж, хууль хэрэглээний болоод зохион байгуулалтын хувьд нэг мөр, ойлгомжтой болохоос гадна хууль хоорондын уялдаа хангагдаж хэрэгжилтийг нэг мөр хангах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг сайжруулах зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар.**

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд бүрэн нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөл нь анхдагч хууль болон батлагдах тул энэхүү харилцааг зохицуулж байсан Сонгуулийн тухай хуулийн Улсын Их Хурлын сонгуулийн харилцааг зохицуулж байсан бүлэг бүхэлдээ хүчингүй болно.

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТҮҮНИЙ ТҮҮХЭН ХӨГЖИЛ<sup>1</sup>**

### **1.1. Сонгуулийн тухай ойлголт**

Хүн төрөлхтний дийлэнх хувийн эдэлдэг улс төрийн эрхийн нэг нь сонгуулийн эрх, ялангуяа сонгох эрх гэж үзэж болно. Энэхүү эрхийг хангах баталгаа нь сонгууль мөн бөгөөд энэ нь ардчилсан Үндсэн хуульд ёсыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болдог. Дэлхийн улс орнуудын хөгжлийн түүхэн чиг хандлагаас үзвэл чөлөөт шударга сонгууль нь ардчилсан төрийн үндэс юм.

Сонгууль буюу санал хураалтын замаар аль нэг байгууллагыг бүрдүүлэх аргыг эрт үеэс хэрэглэж ирсэн түүхтэй. Эртний Грек, Ромын үед сонгууль явагддаг байсан бөгөөд Дундад зууны үед ч түүнийг янз бүрийн хэлбэрээр хэрэглэж байжээ. Гэхдээ тухайн үед сонгууль нь хэлбэрийн төдий байсан нь 18-р зууны эцэс, 19 дүгээр зууны эхэн үеэс сонгуулийн системийн өнөөгийн дүр төрхийг олж, дэлхийн дийлэнх улс орнуудад өргөнөөр хэрэглэгдэх болсон.

Дэлхий нийтийн сонгуулийн хөгжлийг түүхэн хандлагаас үзвэл сонгуулийн тогтолцоог ардчилсан, коммунист, гуравдагч орнуудын сонгууль гэж 3 хувааж болно. Нэг дэх хэсэг буюу ардчилсан системийн сонгууль бүхий орнуудын сонгууль нь нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхэд үндэслэдэг бол, коммунист сонгуулийн тогтолцоо бүхий орнуудад сонгуулийн үйл явцад удирдагчийг сонгох бус зөвхөн тэднийг бататган баталгаажуулахад чиглэгдэж байсан. Энэ тогтолцооны үед удирдан чиглүүлэгч аль нэг намын сүр хүчийг сурталчлан

---

<sup>1</sup>Б.Нармандах., Үндсэн хуулийн эрх зүй, УБ, 2017

харуулахыг зорьдог бөгөөд сонгуулийн оролцоог 100% хэмээн сурталчилдаг байна.

Гуравдагч орнуудын сонгууль нь дарангуйлагчийн засаглалыг бататгах, эрх мэдлээ баталгаажуулах хэсэг бүлэг хүмүүсийн хоорондын дотоод өрсөлдөөнт байдлыг тухайн орнуудын улс төрийн хөгжилтэй нь холбон үздэг. Эдгээр орнуудад орон нутгийн чанартай асуудлыг үндэсний хэмжээний бодлогоос илүү сонирхдог учраас үндэсний төр суларч, улс төр нь сонгууль төвтэй болж чаддаггүй. 1980-аад оны үед Латин Америкчүүд ийм системээр сонгуулиа явуулж байжээ.

Ардчилсан нийгэмд сонгуулийг тогтмол явуулах бөгөөд энэ нь албан тушаалтан огт халагдаж солигдохгүй, насаараа ажиллах явдлыг үгүйсгэж, сонгогдсон албан тушаалтнууд ард түмнийхээ өмнө хариуцлага хүлээж, тодорхой хугацаагаар сонгогдож ажиллана гэсэн үг юм.

Үүнээс үзвэл сонгууль нь аливаа ардчилсан улс гүрнүүдийн нийгэм улс төрийн амьдрал болон эрх зүйн харилцаанд онцгой үүрэг гүйцэтгэдэг нийгэм улс төр, эрх зүйн чухал үзэгдэл бөгөөд энэ нь хүн төрөлхтний нийгэм түүхийн хувьсал, хөгжлийн явцад жам ёсны эрхийн үндсэн дээр бий болж, нийгэм, улс төрийн амьдралд өөрийн зүй ёсны үүргээ гүйцэтгэсээр иржээ. Сонгуулийн онол арга зүйн судалгааны чухал асуудлын нэг бол түүний мөн чанар, үнэт шинж, гүйцэтгэх үүргийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх замаар тодорхойлоход оршино.<sup>2</sup>

Сонгууль нь улс төр, нийгэм, эдийн засаг, хууль, эрх зүй, соёл, оюуны амьдралтай нягт холбоотой олон талт үзэгдэл учир судлаачид түүнийг төрийн онол, эрх зүй, социологи, улс төрийн психологи, түүх зэрэг шинжлэх ухаанууд өөр өөрсдийн судлах зүйл судалгааны түвшин, арга, хандлага зэргийг үндэслэн судалдаг. Тухайлбал: түүх судлаачид "Сонгууль нь хүн төрөлхтний түүхэнд төр, засаглал, ноёрхол ба дарангуйлал үүсэж бий болсон үетэй давхцаж тэдгээртэй нэгэн зэрэг бий болсон түүхэн үзэгдэл" хэмээн тодорхойлж байхад улс төр судлаач А.Цанжид "Сонгууль нь орчин үеийн нийгэмд ардчиллыг хэрэгжүүлэх ганц оновчтой арга хэрэгсэл мөн бөгөөд улс төрийн нийцтэй оролцооны хамгийн түгээмэл хэлбэр нь сонгуульд оролцох явдал юм" гэж бичжээ.<sup>3</sup>

Сонгуулийг хууль, эрх зүйн үүднээс судлах нь институциональ хандлагын хүрээнд багтах бөгөөд энэ нь XVIII зууны үеэс хөрөнгөтний хувьсгалын нөлөөгөөр Үндсэн хуульт хаант засаг, эсхүл Парламентын болон Ерөнхийлөгчийн Бүгд найрамдах засаглалтай төр, түүний засаглалын байгууллага, албан тушаалтныг сонгохтой холбоотойгоор үүсэж хөгжсөн.

Өөрөөр хэлбэл XVII зууны үед Г.Гроци, Б.Спиноза, Т.Гоббс, Ж.Локк нарын сэтгэгчид хүний жам ёсны эрхийг томъёолон боловсруулсан нь бие хүний нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлох, төрөөс тэдгээрийн эрх, эрх чөлөөг ханган хэрэгжүүлэх үүргийг хүлээх явдлын үндэс суурь нь болж, улмаар XVIII зууны үеэс Европын тэргүүний хөгжилтэй орнууд болох Англи, Франц, Голланд зэрэг бусад орнууд феодалын байгуулал, хэмжээгүй эрхт хаант төрийг хөрөнгөтний хувьсгалаар халж, оронд нь капиталист харилцаа, түүнд тохирсон Үндсэн хуульт хаант засаг, эсвэл Парламентын болон Ерөнхийлөгчийн засаглалтай Бүгд найрамдах төр засгийг тогтоож, эдгээрийн үр дүнд төлөөллийн ардчилал хөгжих болсон төдийгүй, энэ үед улс төрийн цоо шинэ институт, байгууллага болох улс төрийн намууд үүсэн бүрэлдэж, улсын Ерөнхийлөгч, Парламентыг сонгох сонгуульд гол субъект болон оролцох болсон байна. Тиймээс ч энэ үеэс сонгууль нь төрийн засаглалын дээд байгууллага, төрийн өндөр албан тушаалтныг сонгох хэрэгсэл болж төлөвшин, хууль, эрх зүйн биеэ даасан институт болон хөгжих болсон ажээ.

<sup>2</sup>"Конституционное право зарубежных стран" Том1, М., 1996

<sup>3</sup>А.Цанжид. Улс төрийн шинжлэх ухаан, УБ., 1996, 75 дахь тал.

Үүнээс үзэхэд ардчилсан сонгууль нь бодит утга агуулгаараа хүн төрөлхтний түүхэнд хаант засаг ноёрхсон нөхцөлд биш, харин Ерөнхийлөгчийн буюу Парламентын засаглалын үед тэдгээрийг сонгох замаар XVII зууны үед үүсэж бий болсон гэж үзэх үндэслэлтэй.

Сонгууль нь XIX зуунаас XX зуунд онолын үзэл баримтлал, зохион байгуулалт, технологи, практикийн талаар улам боловсронгуй болж, бүх нийтийн, тэгш саналыг шууд, нууцаар гаргах, чөлөөтэй өрсөлдөөнтэй байх зарчмуудын дагуу хувьсан хөгжиж, улмаар орчин үед төр засгийн төлөөллийн болон цөөн улс оронд гүйцэтгэх, шүүх, орон нутгийн засаг захиргааг сонгож зохион байгуулах илүү ардчилсан, зүй зохистой арга хэрэгсэл, механизм болон төлөвшжээ.

## **1.2. Монгол Улс дахь сонгуулийн түүхэн хөгжил**

Монгол Улсад одоо бүрэлдэн төлөвшиж байгаа сонгуулийн шинэ тогтолцооны талаарх асуудлыг судлахдаа өмнөх түүхэн үеүүдэд бүрэлдэн тогтсон сонгуулийн хуучин тогтолцоотой харьцуулан үзэх замаар тэдгээрийн ялгаа, өмнөх үеийн сонгуулийн тогтолцооны шинж, чанар, түүхэн ба улс төрийн сургамж, алдаа дутагдал, ололттой тал зэргийг харьцуулах замаар дүгнэн үзэх нь зүйтэй бөгөөд энэ талаар судлаачдын бичсэн бүтээлүүдийг<sup>4</sup> сонирхон үзвэл зарим нь Монголчууд бид эзэн хаанаа сонгодог байсан гэж үүнийг нотлохыг ч оролддог байна. Гэвч энэ үеийн хааныг сонгох явдал нь зөвхөн алтан ургийнхны онцгой эрх байсан бөгөөд жинхэнэ ардчилсан сонгуулийн шинж үгүйсгэгдэж байснаас үзвэл бид төрт ёсны түүхийн бүхий л үеийн турш сонгуулийг тогтмол хэрэглэж байгаагүй гэж үзэж болно. Түүх болон эрх зүй судлаачдын дийлэнх нь Монгол улсын сонгуулийн тогтолцооны хөгжлийг гол төлөв 1921 оноос үүсэлтэй гэж үзжээ. Үүний дагуу Монгол улс дахь сонгуулийн хөгжлийг:

- 1921-1924 он буюу засаг төрийн байгууллага, төрийн албан тушаалтныг ард олон өөрсдөө сонгох оролдлогыг анх удаа хийсэн сонгуулийн тогтолцооны эх үүсвэр тавигдсан үе
- 1924-1949 он буюу Монгол улсад анги ялгаварласан, бүх нийтийн бус, олон шаттай, өвөрмөц тогтолцоо бүхий тогтмол бус үйлчлэлтэй, тоталитар дэглэмийн ноёрхлын үеийн сонгуулийн тогтолцооны үе
- 1951-1990 он буюу сонгуулийн системийг бүхэлд нь хэлбэрийн хувьд шинэтгэж, бүх нийтийн, саналаа нууцаар гаргах, тэгш, шууд сонгууль төлөвшүүлэх нэрийдлээр агуулга, мөн чанар, зорилго нь илт гажуудсан томилгоог баталгаажуулсан сонгуулийн тогтолцоог хүлээн зөвшөөрсөн үе
- 1990 оноос хойших буюу сонгуулийн ардчилсан зарчмуудыг бодитойгоор хэрэгжүүлж эхэлсэн үе гэсэн үеүүдэд хувааж болно.

Монгол Улсад сонгуулийн систем үүсэж бүрдэхэд Монгол Улсын анхны бичмэл Үндсэн хуулийг баталж, Бүгд Найрамдах засаг тогтсон явдал чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Монгол Улсын анхны Үндсэн хуульд Монгол оронд шинээр үүсэн бүрэлдэж байгаа сонгуулийн тогтолцоог хуульчлан зааж, "Сонгох, сонгогдох эрхийн тухай" гэсэн тусгай дөрөвдүгээр бүлгийг оруулсан нь сонгуулийн үзэл санааны хөгжил болон практикт төлөвшихөд онцгой үүрэг гүйцэтгэжээ. Үндсэн хуулийн энэ бүлэгт сонгуулийн тогтолцооны гол зарчим, зорилго, хэм хэмжээ, эрх зүйн зохицуулалтыг хуульчлан зааж өгчээ. Үүнд:

БНМАУ-ын төрийн эрх барих байгууллага нь бүх шатны Ардын Хурал болох бөгөөд энэ Хурлыг байгуулж, хууль ёсны болгох улс төрийн процедур, хэлбэр бол Ардын Хурлын сонгууль мөн гэдгийг тодорхойлж, сонгууль нь тогтмол нэг жил

---

<sup>4</sup> БНМАУ-ын түүх. 3 дугаар боть, УБ., 1969  
И.Дашням. БНМАУ-ын сонгуулийн систем, УБ., 1975  
Л.Тойв. БНМАУ-ын сонгуулийн систем, УБ., 1950.

тутамд явагдаж байх, сонгуулийг олон шаттайгаар явуулах, сонгох, сонгогдох эрх нь адил тэгш байх, анги ялгаварласан зарчимд тулгуурласан байхаар тогтоожээ. Хуулийн зүйл, заалтаас үзвэл уг Үндсэн хуулиар нийт ард иргэд, эмэгтэйчүүдийг сонгуулийн эрхтэй болгосон боловч, худалдаачид, мөнгө хүүлэгчид, ван, хан, гүн, хутагт хувилгаад, тайж, лам нарын сонгуулийн эрхийг хязгаарласнаар сонгуулийн тэгш эрхийн зарчмыг үгүйсгэж байжээ.

Анхны Үндсэн хуульд, сонгуулийг тусгай дүрэм баримтлан явуулахаар тогтсон нь сонгуулийн талаар анхны төрөлжсөн бие даасан эрх зүйн баримт бичиг гарах хууль зүйн үндэс нь болсон бөгөөд энэ нь 1925 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Улсын 2 дугаар бага хурлын 4 дүгээр тогтоолоор батлагдсан "БНМАУ-ын Их Хурлын Төлөөлөгчдийг сонгох дүрэм" юм. Үүгээр засаг захиргааны бүх байгууллагыг доороосоо дээр хүртэл сонгох журамтай болгон, сонгогчдынхоо өмнө заавал тайлагнаж байх журмыг тогтоож байжээ.

Түүнчлэн 1949 оныг хүртэл сонгууль олон шаттай явагдаж, саналаа ил гаргаж байсан ба 1949 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр уг тогтолцоог халж, нийтээрээ, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах замаар сонгуулийг явуулах журамд шилжсэн байна. 1950-1990 он хүртэлх хугацаанд сонгуулийн уг системийг хэрэглэж, АИХ-ыг сонгох сонгууль 2 удаа, орон нутгийн АДХ-ыг сонгох сонгууль 65 удаа тус тус явагдаж байснаас харвал сонгууль тогтмол явагдаж байжээ. Гэвч энэ нь уг чанартаа чөлөөт биш бэлгэдлийн төдий байж, нийгэмд тогтсон нэг намын дэглэм, захиран дарангуйлах засаглалын улмаас сонгуулийн тогтолцооны ардчилсан шинж чанар алдагдсан.

Монгол Улс 1990 оноос хойших хугацаанд улс төрийн амьдралд гарсан өөрчлөлт шинэчлэлтэй уялдан сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох, түүнийг шинэчлэх, өөрчлөх, ардчилалтай холбох алхмуудыг хийж эхэлсэн. Үүний үр дүнд 1992 оны Үндсэн хуулийг шинээр баталж, түүнд сонгуулийн системийн зарчмуудыг шинэчлэн баталгаажуулж 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016<sup>5</sup> онуудад Улсын Их Хурлын гишүүний<sup>6</sup>, 1993, 1997, 2001, 2005, 2009, 2013 онуудад Ерөнхийлөгчийн сонгууль болон орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль тус тус явагджээ. Өнөөдөр дээрх субъектүүдийг сонгох сонгуулийн үйл

---

<sup>5</sup>Монгол Улсын Их Хурлын 6 дахь удаагийн сонгууль явагдаж томсгосон 26 тойрогт 11 нам, 2 эвслээс болон бие даан 354 нэр дэвшигч, намын нэрийн жагсаалтаар 190 нэр дэвшигч өрсөлдөж, сонгогчдын санал авах ажиллагааг автомат төхөөрөмжөөр авсан бөгөөд сонгогчдын 67.29 хувь нь саналаа өгчээ. Мөн анх удаа Монгол Улс гадаад оронд оршин суугаа иргэдийнхээ саналыг авсан.

<sup>6</sup>**1992 оны** УИХ-ын сонгуульд МАХН үнэмлэхүй ялалт байгуулж, 76 суудлын 70-ыг, сөрөг хүчин болох МСДН 1, МоАН, Нэгдсэн Нам, МҮДН-ын эвсэл 4 суудал авсан бол МАХН-ын гишүүн Гэндэнсамбуугийн Зуунай бие даан нэр дэвшиж сонгогдсон. Уг сонгууль нь томсгосон мажоритар системээр буюу, аймаг дүүргүүдийг нэг тойрог болгон, тойрог тус бүрээс 2-4 хүн сонгогдож байжээ.

**1996 оны** сонгууль нь жижигсгэсэн мажоритар систем буюу 76 тойрог тус бүрээс 1 хүн сонгогдсон бөгөөд УИХ-ын сонгуульд МҮАН, МСДН-ын "Ардчилсан Холбоо" эвсэл 50 суудал авснаар Засгийн газраа бүрдүүлэх эрхтэй болсон. Харин МАХН анх удаа сөрөг хүчин болсон тус сонгуулиар 25 суудал авч, үлдсэн нэг суудлыг МУНН /Очирбатын Дашбалбар/ эзэлжээ.

**2000 оны** сонгууль. Сонгуулийн тогтолцоо өмнөхтэйгээ ижил байсан бөгөөд МАХН 72 суудал авч үнэмлэхүй олонхи болж, МҮАН, МШАН-ын "Ардчилсан Холбоо" эвсэл, ИЗН, Ногоон Намын "Иргэний Зориг-Ногоон Нам" эвсэл, Эх Орон-МАШСН тус бүр 1 суудал авч, бие даагч 1 хүн /Ламжавын Гүндалай/ сонгогджээ.

**2004 оны** сонгууль. МАХН 36, Ардчилсан Нам, Эх Орон Намын "Эх орон-Ардчилал" эвсэл 36, БНН 1 суудал авч, Ардчилсан Намын 3 гишүүн бие даан нэр дэвшиж сонгогдсон.

**2008 оны** Улсын Их Хурлын сонгууль. МАХН 45, Ардчилсан Нам 28, Ногоон Нам, Иргэний Хөдөлгөөний Намын "Иргэний эвсэл" 1, ИЗН 1, бие даагч 1 /Зоригийн Алтай/ сонгогдсон.

**2012 оны** Улсын Их Хурлын сонгууль. Ардчилсан нам 34, МАН 26, МАХН-МҮАН-ы Шударга ёс эвсэл 11, Иргэний Зориг Ногоон Нам 2 суудал авч, 3 бие даагч сонгогдсон.

**2016 оны** Улсын Их Хурлын сонгууль. МАН 65, Ардчилсан Нам 9, МАХН 1, бие даагч 1 сонгогдсон.

ажиллагааны эрх зүйн үндсийг тус тусынх нь хуулиар зохицуулж байгаа боловч үүнийг бүрэн төгс шийдэгдсэн гэж үзэж хараахан болохгүй.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

### 2.1. Сонгуулийн эрх зүйн ойлголт

Хууль зүйн шинжлэх ухаан тэр дундаа Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны үүднээс сонгуулийн тухай ойлголтыг:

1. Сонгуулийн эрх зүй
2. Сонгох, сонгогдох эрх
3. Сонгуулийн тогтолцоо гэсэн ойлголтуудын хүрээнд авч үзнэ.

Эдгээрээс сонгуулийн эрх зүй гэсэн ойлголтыг авч үзвэл энэ нь Үндсэн хуулийн эрх зүйн нэг бие даасан институт мөн бөгөөд төрийн сонгуульд албан тушаалд нэр дэвшүүлэх, сонгуулийг бэлтгэх, явуулах, үр дүнг гаргахтай холбогдон үүсэх нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц юм.

Сонгуулийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байгаа нийгмийн харилцаа нь өөрийн объект, субъект, хууль зүйн факт, агуулгатай байна.

*Сонгуулийн эрх зүйн харилцааны объект нь сонгуулийн эрх зүйн харилцаанд оролцогчдын зан үйл чиглэж байгаа зүйл буюу сонгууль өөрөө байна. Сонгууль гэдэг нь нэг талаас нийтийн засаглалыг бий болгох үйл ажиллагаа, нөгөө талаас төрийн дээд албан тушаалтнуудыг халж сэлгэх хэрэгсэл юм.*

Сонгууль нь нийгэмд дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Сонгууль нь нийтийн засаглалыг байгуулах гол арга хэрэгсэл болдог. Өөрөөр хэлбэл Парламент буюу ард түмний төлөөллийн дээд байгууллага, төрийн тэргүүн, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг, зарим цөөн оронд шүүх, Засгийн газрыг байгуулахад сонгууль үндсэн арга хэрэгсэл нь болдог.
- Сонгууль нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хангах боломжийг бий болгоно. Энэ талаар 1948 онд НҮБ-аас баталсан Хүний эрхийн түгээмэл Тунхаглалын 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Ард түмний хүсэл зориг бол засаг төрийн үндэс мөн. Мөн хүсэл зориг нь бүх нийтэд сонгуулийн тэгш эрх эдлүүлэх үндсэн дээр саналыг нууцаар хураах, эсхүл саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр бусад хэлбэрийг хангах замаар тогтмол, хуурамч бус сонгууль явуулахад илрэлээ олно" гэж заасан нь дэлхий нийтээр сонгох эрхийг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл бол бүх нийтийн сонгууль гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэрэг юм.
- Ард иргэдийн зүгээс засаг төрийн байгууллага, удирдлагыг хянах боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл сонгогдогч сонгогчдын эрх ашиг, сонирхлыг төлөөлж чадаж байгаа эсэхийг хянаж, шаардлагатай гэж үзвэл огцруулах үндэслэл журмыг хуульчилсан байна.
- Сонгогчдын өөрсдийнх нь улс төр, хууль эрх зүйн ухамсар, соёл, туршлага, сэтгэл зүйн түвшин, шинж төлөвийг илэрхийлэх боломжийг олгоно.
- Сонгууль нь улс төрийн амьдралын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлдог хэмжүүр нь болдог. Өөрөөр хэлбэл сонгуулийн явцад улс төрийн хүчнүүдийн ашиг сонирхол, үзэл бодол ямар байгаа нь илүү тод харагддаг төдийгүй тэдэнд ард түмний зүгээс тодорхой үнэлэлт өгч, улс төрийн амьдралын цаашдын чиг хандлагыг тодорхойлох боломжийг бий болгодог.
- Сонгууль нь улс төрийн удирдагчдыг халж сэлгэх боломжийг олгодог.

**Сонгуулийн хэлбэр.** Сонгуулийн хэлбэр нь түүний илрэн гарах гадаад дүр төрх нь юм. Сонгууль нь хэлбэрийн хувьд шууд ба шууд бус гэсэн үндсэн 2 хэлбэртэй байна.

Сонгууль нь сонгогчдыг хамарч байгаа цар хүрээний хувьд



- Бүх нийтийн ба
- Хэсэгчилсэн сонгууль гэсэн хэлбэртэй байна.

*Бүх нийтийн сонгууль нь* нийт улс орон даяар, сонгуулийн эрх бүхий иргэдээс бүгд оролцох боломжийг хангасны үндсэн дээр явуулж байгаа сонгуулийг ойлгоно. Харин *хэсэгчилсэн сонгууль нь* тодорхой орон нутгийн хүрээнд буюу тойрог, хэсгийн хүрээнд явуулах сонгуулийг хэлнэ.

Мөн сонгууль нь цаг хугацааны хувьд шинэ сонгууль, нөхөн сонгууль, дахин сонгууль гэсэн төрөлтэй байна.

*Шинэ сонгууль* нь хуулиар тогтоосон хугацааны дагуу тогтмол явагдах ээлжит сонгуулийг хэлдэг бол *нөхөн сонгууль* нь тодорхой шалтгаанаар аль нэг тойргоос сонгогдсон төлөөлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд буюу мандатын эрх суларсан үед түүний орны төлөөлөгчийг сонгох үүднээс явуулж буй сонгуулийг хэлнэ.<sup>7</sup> Харин *дахин сонгууль* нь сонгуулийн санал хураалтын үр дүнг тодорхойлох боломжгүй болсон үед хуульд заасан үндэслэл журмын дагуу явуулах сонгуулийг хэлнэ. Дахин сонгууль нь бүх нийтийн болон хэсэгчилсэн сонгуулийн аль ч хэлбэрээр явагдаж болно.

*Сонгуулийн эрх зүйн харилцааны субъект нь* нийтийн засаглалыг байгуулах болон төрийн тэргүүнийг сонгох, тэдгээрт сонгогдох эрх эдэлж, үүрэг хүлээх эрхийн чадвар, чадамж бүхий иргэд, улс төрийн нам, эвсэл байна. Эдгээр субъектийн эрх үүргийн нэгдэл нь сонгуулийн эрх зүйн харилцааны агуулгыг илэрхийлээд зогсохгүй *сонгох, сонгогдох эрхийн* агуулгыг мөн илэрхийлнэ. Үүнд:

Монгол Улсын иргэдийн сонгох эрх нь 18 наснаас, сонгогдох эрх нь тодорхой албан тушаал бүрд харилцан адилгүй наснаас эхлэх бөгөөд энэ нь хуульд заасан субъектив шалгуур буюу тусгай болзол шаардлагыг хангасан тохиолдолд эхэлнэ. Тухайлбал: Монгол Улсын Ерөнхийлөгчөөр 50 нас хүрсэн<sup>8</sup>, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг сонгоно. Дээрх эрхүүдийн хэрэгжих хэлбэр, үйл явц, нөхцөл баталгааг Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын сонгуулийн тухай хуулиудад нарийвчлан заасан байдаг.

*Сонгуулийн эрх зүйн харилцааны хууль зүйн факт нь* уг эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгоход чиглэгдсэн хуульчлан тодорхойлогдсон бодит нөхцөлүүд байна.

Сонгуулийн эрх зүйн харилцаа үүсэх, өөрчлөгдөх үндэслэл нь төрийн тодорхой албан тушаалтан цаашид бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох явдал юм. Харин сонгогчдоос төрийн дээд албан тушаалтан, төлөөлөгчдийг сонгож, эрх бүхий субъектээс бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрснөөр дуусгавар болж болно. Мөн байгалийн болон давагдашгүй хүчний нөлөөллийн улмаас сонгуулийн эрх зүйн харилцаа өөрчлөгдөж, дуусгавар болж болно. Өөрөөр хэлбэл, хууль зүйн факт нь хүсэл зоригоос хамааралтай ба хамааралгүй байж болно.

<sup>7</sup>1992-1996 онд хэрэгжиж байсан хуулиар УИХ-ын гишүүний орон гарахад нөхөн сонгууль болдоггүй, үндсэн сонгуульд дараагийн санал авсан хүн шууд сонгогддог байв. Мөн бүрэн эрхийн хугацаа дуусахад 1 жилээс бага хугацаа үлдсэн бол орных нь хүнийг сонгох сонгууль болдоггүй.

1996-2000. Н.Багабанди ерөнхийлөгчөөр сонгогдож, С.Гончиг, М.Чимидцэрэн, С.Зориг нар нас барсны улмаас нөхөн сонгуулиуд болсон. Үүнд Н.Энхбаяр, Ц.Өөлд, Д.Цэвээнжав, С.Оюун нар сонгогдсон бол О.Дашбалбар нас барахад бүрэн эрхийн хугацаа 1 жилээс бага үлдсэн байсан тул нөхөн сонгууль болоогүй.

2000-2004. Л.Энэбиш, М.Зэнээ нар нас барж, нөхөн сонгуулиуд болоход Б.Өвгөнхүү, Су.Батболд нар сонгогдсон.

2004-2008. Н.Энхбаяр ерөнхийлөгчөөр сонгогдож, О.Энхсайхан нас барсны улмаас нөхөн сонгууль зохион байгуулагдаж, М.Энхболд, Ө.Энхтүвшин нар сонгогдсон байна.

2008-2012. Ц.Элбэгдорж ерөнхийлөгчөөр сонгогдсон тул нөхөн сонгууль болж, Даш.Зоригт сонгогджээ.

<sup>8</sup>Монгол улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 30.2 дахь хэсэг, Төрийн мэдээлэл, 2019, №45 /1098/

*Сонгуулийн эрх зүйн эх сурвалж.* Сонгуулийн эрх зүйн эх сурвалж гэж сонгуулийн харилцааг зохицуулж буй хэм хэмжээнүүдийн илрэн гарах гадаад хэлбэр юм. Уг эх сурвалжийг хууль зүйн хүчин чадлаар нь үндсэн эх сурвалж, гол эх сурвалж, бусад эх сурвалж хэмээн ангилна.

Сонгуулийн эрх зүйн үндсэн эх сурвалж нь Монгол Улсын Үндсэн хууль мөн. Учир нь чөлөөт ардчилсан сонгуулийн үндсэн зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлд "Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй шууд сонгох эрхтэй оролцож, саналаа нууцаар гаргана" хэмээн бататгажээ.

Харин гол эх сурвалжид сонгуулийн харилцааг зохицуулах хэм хэмжээг бүхэлд нь агуулж байгаа Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль зэрэг уг харилцааг шууд зохицуулагч хуулиуд тус тус багтана.

Бусад эх сурвалжид сонгуулийн харилцааг зохицуулахаар үндсэн ба гол эх сурвалжид нийцүүлэн тогтоосон хууль, хуульчилсан актууд багтана. Тухайлбал, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, дээрх хуулиудыг тайлбарласан Улсын Дээд Шүүхийн албан ёсны тайлбар, Сонгуулийн Ерөнхий Хорооноос гаргасан бусад шийдвэрээс бүрдэнэ.

## **2.2. Сонгуулийн эрх зүйн зарчим**

Сонгуулийн эрх зүйн харилцаанд оролцогчдоос уг эрх зүйн хэм хэмжээг тогтоох, түүнийг хэрэгжүүлэхдээ зайлшгүй баримталбал зохих үзэл баримтлалыг сонгуулийн эрх зүйн зарчим гэнэ. Сонгуулийн эрх зүйн зарчмыг үндсэн зарчим, тусгай зарчим гэж ангилан үзнэ.

Эдгээрийн хууль зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт хуульчлан бататгасан байна.

Сонгуулийн үндсэн зарчимд:

- Сонгууль бүх нийтийн байх
- Сонгууль шууд байх
- Сонгууль чөлөөт байх
- Саналаа нууцаар гаргах зарчмууд багтана.

*Сонгууль бүх нийтийн байх зарчим.* Уг зарчмын агуулга нь сонгуульд оролцох эрхийг иргэдэд хуулиар хэрхэн олгосноор тодорхойлогдоно. Сонгууль бүх нийтийн байна гэдэг нь сонгууль явуулах өдөр эх орондоо байгаа, сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ оролцохыг ойлгоно. Гэвч амьдрал дээр бүх хүнийг сонгуульд оролцуулах боломж байдаггүй бөгөөд хуулиар зарим нэгэн хязгаарлалтыг тогтоодог. Тухайлбал:

Эдгээрээс гадна зарим улс оронд эд хөрөнгийн болон бичиг үсгийн хязгаарлалтыг тогтоож өгдөг.<sup>9</sup> Мөн тухайн оронд оршин суусан хугацааг харгалзан сонгуулийн эрх олгох, цэргийн алба хаагч, эмэгтэйчүүд, хөлсний ажилтан, ядуучууд, нутгийн уугуул хэл мэдэхгүй хүмүүсийн сонгуулийн эрхийг хязгаарладаг практик цөөн орнуудад хэрэглэгддэг байна.<sup>10</sup>

*Сонгууль шууд байх зарчим.* Сүүлийн үед зарим улс төрчид, судлаачид сонгуулийг хувь тэнцүүлэх аргаар явуулбал Үндсэн хуульд заасан шууд зарчим зөрчигдөх мэтээр ярьж, бичдэг. Энэ нь тийм биш харин сонгогч саналаа нэр дэвшсэн хүний ч, нам эвслийн ч төлөө өгч болох бөгөөд гагцхүү саналаа хэн нэгний төлөөлөлгүйгээр, өөрөө шууд өгөхийг сонгууль шууд байна гэж ойлгоно.

<sup>9</sup>Гадаад орнуудын парламентын туршлагаас, УБ.,1992

<sup>10</sup>А.Жамбал. Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо, УБ., 2000, 37 дахь тал.

*Сонгуулийн чөлөөт байдлын зарчим.* Сонгуульд оролцох, эс оролцох /Абсентеизм-сонгууль болон ард нийтийн санал асуулгын санал хураалтад сонгогчид оролцохоос зайлсхийсэн улс төрийн үзэгдэл/<sup>11</sup>, хэний ч дарамт шахалтад оролгүйгээр саналаа илэрхийлэх, нэр дэвшигчийг бүгдийг татгалзах зэргээр сонгуулийг чөлөөт байдлын зарчим хэрэгжинэ. Сонгуулийн бүх нийтийн зарчим нь сонгуулийн чөлөөт зарчмыг хөндөх ёсгүй. Өөрөөр хэлбэл сонгууль бүх нийтийн байх зарчмыг хангах үүднээс сонгуулийн эрх бүхий иргэдийг албадан сонгуульд оролцуулахаар шаардаж, иргэдийг сонгуульд оролцоогүйн төлөө ямар нэгэн хариуцлага хүлээлгэхгүй бөгөөд сонгуульд нам, эвсэл, бие даан нэр дэвшигч чөлөөтэй оролцох боломжийг бүрдүүлсэн байхыг ойлгоно. Бүх нийтээрээ сонгуульд оролцох эрх, боломжийг хуулиар бүрдүүлж, түүнийг эдлэх эсэх нь уг иргэний сайн дурын хэрэг юм.

*Саналаа нууцаар гаргах зарчим.* Сонгогч хэний ч нөлөөнд автахгүй зөвхөн өөрийн ухамсраар саналаа илэрхийлэх боломжийг нууц санал хураалт олгодог. Уг зарчмыг хэрэгжүүлэх үүднээс сонгууль явуулах өдөр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүрэлцэн ирэх боломжгүй хүмүүс/өндөр настан, хэвтрийн өвчтэй хүмүүс/-ийн саналыг Сонгуулийн Хорооноос саналын хайрцаг явуулах замаар саналыг нь авдаг. Харин сонгогч өндөр настай, бичиг үсэг үл мэдэх зэрэг шалтгаанаар итгэмжилсэн төлөөлөгчөөс тусламж авч болно. Гэхдээ энэ нь сонгуулийн чөлөөт байдлын зарчимд илт харшилсан байх ёсгүй.

Сонгуулийн эрх зүйн тусгай зарчим нь сонгуулийн өөрийнх нь мөн чанараас үүсэн гарах бөгөөд энэ талаар сонгуулийн төрөлжсөн хуулиудад хуульчилсан байдаг. Үүнд:

- *Хууль дээдлэх*
- *Ил тод байдлыг хангах*
- *Шударга ёсыг сахих*
- *Сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд нэгдсэн журмаар эхлэх, дуусах*
- *Маргааныг шуурхай, үндэслэлтэй, хуулийн хүрээнд шийдвэрлэх*
- *Сонгогчийн эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх*
- *Энгийн ойлгомжтой байх.*<sup>12</sup>

### **2.3. Сонгуулийн тогтолцоо**

Сонгуулийн тогтолцоо нь аливаа улс орны түүхэн уламжлал, улс төрийн систем, улс төрийн дэглэм, хүн амын улс төрийн боловсрол, соёлын түвшин, нийгэм дэх улс төрийн хүчнүүдийн харьцаа зэрэг хүчин зүйлүүдээс хамаарч тус бүрийн өвөрмөц онцлогтой байдаг.

Сонгуулийн тогтолцоо нь өргөн утгаараа сонгууль явуулахтай холбогдон үүссэн, сонгууль явуулах журмуудаар зохицуулагдсан нийгмийн харилцааны цогц мөн. Явцуу утгаараа сонгогчдын өгсөн саналын үр дүнгээр нэр дэвшигчдэд суудал хуваарилах аргыг хэлдэг. Энэхүү суудал хуваарилах аргад үндэслэн сонгуулийн тогтолцоо нь

- *Мажоритар тогтолцоо*
- *Пропорциональ буюу хувь тэнцүүлэх тогтолцоо*
- *Холимог тогтолцоо гэсэн төрөлтэй.*

*Мажоритар тогтолцоо* нь Францын *majorite* буюу олонх гэсэн үгнээс гаралтай, нэр дэвшигчийг олонхын саналаар сонгох арга юм. Энэ аргаар сонгууль явуулж байгаа тохиолдолд сонгогчид зөвхөн нэр дэвшүүлсэн хүний төлөө

<sup>11</sup>Д.Солонго. Төрийн эрх зүйн тайлбар толь, УБ., 2003

<sup>12</sup> Сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2016, №4

саналаа өгдөг. Энэ аргыг нэг ба олон мандаттай тойрогт хэрэглэж болно. Тухайлбал: Монгол Улс энэ тогтолцоогоор 1992, 2008 оны Улсын Их Хурлын сонгуулийг олон мандаттай 26 тойрогт явуулсан бол, 1996, 2000, 2004, 2016 оны Улсын Их Хурлын сонгуулийг нэг мандаттай 76 тойрогт явуулсан.

Мажоритар тогтолцоо бүхий улс орнууд нэр дэвшигчийг сонгогдсонд тооцохдоо

1. Харьцангуй олонхын
2. Ердийн олонхын
3. Дийлэнх олонхын гэсэн зарчмуудыг баримталдаг.

*Харьцангуй олонхын зарчмыг* баримталдаг сонгуулийн мажоритар тогтолцоог манай улс хэрэглэж байгаа бөгөөд энэ нь хэн нэг нэр дэвшигч тойрогтоо нэр дэвшсэн бусад нэр дэвшигчдээсээ олон санал авсан тохиолдолд түүнийг сонгогдсонд тооцдог арга юм. Үүнийг зарим улс төрчид *плюраль* сонгуулийн тогтолцоо гэж нэрлэх бөгөөд<sup>13</sup> энэ системийн үед сонгогдогч маш бага төлөөллөөр сонгогдох магадлал их учир зарим улс орон саналын доод хязгаар тогтоож өгдөг. Энэхүү доод хязгаарыг *босго оноо* гэж нэрлэх бөгөөд дэлхийн улс орнуудад энэ босгыг ойролцоогоор 30 хүртэлх хувиар тогтоодог.

Манай улс 1992, 1996, 2000, 2004, 2008, 2016 оны Улсын Их Хурлын гишүүний сонгуулийг дээрх зарчмаар явуулсан бөгөөд сонгуулийн босгыг тогтоож өгсөн. Энэ аргачлал нь Их Британи, АНУ, Энэтхэг зэрэг орнуудад хэрэглэгддэг.

*Ердийн олонхын зарчмаар* сонгогдсонд тооцохдоо нэр дэвшигчийг сонгогчдоос өгсөн хүчинтэй саналын 50%+1 буюу сонгогчдын саналын талаас илүү хувийн санал авсан байхыг шаардана. Энэ системийн үед нэр дэвшигч бусдаасаа илүү санал авсан ч тавиас илүү хувийн санал авч чадаагүй бол түүнийг сонгогдсонд тооцохгүй. Тиймээс сонгууль олон шаттай явагдах, цаг, хөрөнгө, хүч зарсан нүсэр ажиллагаа үүсэхэд хүрдэг учир сонгуулийг эхний санал хураалтаар дуусгахын тулд шилжих саналын аргыг ашигладаг.

*Дийлэнх олонхын зарчмаар сонгох* системийн үед нэр дэвшигч сонгогчдын гуравны хоёр буюу дөрөвний гурван хувийн санал авч байж ялсанд тооцох бөгөөд энэ нь нэлээд өндөр шалгуур бүхий аргачлал юм. Сонгуульд олон нам оролцох тохиолдолд ийм өндөр хувийн санал авах магадлал тун бага учраас энэ аргыг төдийлөн дангаар хэрэглэдэггүй бөгөөд голдуу Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг тооцоход хэрэглэдэг. Энэ системээр сонгууль явуулахад сонгууль нь ихэвчлэн 2 шаттай байх бөгөөд эхний санал хураалтаар нэр дэвшигчийн хэн нэг нь дийлэнх олонхын санал авч чадаагүй тохиолдолд хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчийг дахин санал хураалтад оруулж ердийн олонхын саналаар сонгоно. Энэ нь Франц болон түүний хараат байсан орнуудад хэрэглэгддэг.

Сонгуулийн мажоритар болон плюраль тогтолцоо нь:

1. Санал өгөх, хуваарилах зарчим нь энгийн, сонгогчдод ойлгомжтой
2. Сонгогчид болон нэр дэвшигчид нүүр тулан уулзаж, нэр дэвшигч хэн бэ гэдгийг илүү сайн мэдсэний үндсэн дээр саналаа өгдөг
3. Сонгуулийн тойргуудад хүчтэй цөөн нам, эвсэл Парламентад төлөөлөгдөх магадлал ихтэй учир улс төрийн намууд эвсэх, нэгдэх үйл явцад эергээр нөлөөлдөг.
4. Сонгогчид Парламентын гишүүний үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох боломж илүү байдаг зэрэг эерэг талтай боловч дараах сөрөг үр дагавруудыг үүсгэдэг.

Үүнд:

---

<sup>13</sup>Шинэ толь. 1999 он, №25, 40 дэх тал.

- Сонгогчдын өгсөн саналын харьцаа алдагдсан үр дүн гардаг. Хамгийн муугаар бодоход ганц нам бүх суудлыг авч, нөгөөх нь юу ч үгүй хоцорч болох юм.
- Улсын Их Хурал популистуудаас бүрдэж аль ч нам олонх болж чадахгүй ингэснээрээ Засгийн газар байгуулах, түүнийг ажиллуулахад төвөгтэй байдал үүсэж болзошгүй.
- Улсын Их Хурлын гишүүд төрийн бодлогыг тодорхойлохдоо ямагт тойрог руугаа чангааж улсын нийтлэг эрх ашиг хохирох талтай
- Нутгийнхныг сонгох сэтгэл зүйн хандлага илүү байдаг.
- Парламентын гишүүн нам хоёрын хоорондын хариуцлагын зарчим алдагдах магадлалтай гэх мэт нотлогдсон олон дутагдал дурдаж болно.

Мажоритар системийн сөрөг нөлөөг арилгах үүднээс сонгуулийн өөр системийн хайгуулд гарсны үр дүнд XIX зууны эцэст анх Серб улсад 1888 онд, дараа нь Бельгид 1899 онд сонгуулийн пропорциональ тогтолцоог хэрэглэжээ.

*Пропорциональ буюу хувь тэнцүүлэн сонгох арга* нь сонгогчдын өгсөн саналтай хувь тэнцүүлэн суудал хуваарилдаг арга юм. Энэ аргыг дэлхийн олон оронд хэрэглэдэг бөгөөд сонгуулийн тойрог томрох тусам түүний үр дүн сайн байдаг. Зарим үед жижиг улс бүхэлдээ 1 тойрог болох ч практик байдаг. Жишээ нь: Израилын Кнессет 120 депутатыг нэг тойргоос сонгодог байна.

Энэ тогтолцооны үед сонгогч голчлон тодорхой нам, эвслийн төлөө саналаа өгдөг. Тухайн намд сонгогчдоос авсан саналын хувьтай тэнцэх суудал хуваарилж, тэр суудалд намын нэр дэвшигчид урьдчилан тогтоосон жагсаалтын дарааллаар сонгогддог ерөнхий зарчимтай. Үүнээс өөр олон хувилбарыг ашиглаж болно. Тухайлбал нас, нам, эвсэлд ажилласан жил, улс төрийн тавцан дахь нэр хүнд зэргийг харгалзах, нам дотооддоо олонхын саналаар сонгууль явуулах гэх мэт.

Хувь тэнцүүлэн суудал хуваарилахад нэг нэр дэвшигчийн авч болох хамгийн бага саналын тоо буюу сонгуулийн КВОТ-ыг ашигладаг. КВОТ-ыг тогтоох олон янзын арга байдаг.<sup>14</sup>

1. 1855 онд Английн өмгөөлөгч Томас Хэр КВОТ нь нийт саналын тоог мандатын тоонд хуваасантай тэнцэнэ гэж тодорхойлоод квотыг аль нэг нам, эвслийн авсан нийт саналд хувааж түүнд ногдох суудлыг тогтооно. Бүх суудал шууд хуваарилагдахгүй бөгөөд энэ тохиолдолд үлдсэн суудлыг хамгийн их саналын үлдэгдэлтэйгээс нь эхлэн хуваарилах, зарим улсад шодох, хамгийн ахмад настайг нь сонгох зэрэг аргаар хуваарилдаг байна.

$$Q = \frac{\text{хүчинтэй саналын тоо}}{\text{мандатын тоо}} \quad Q = \text{КВОТ}$$

2. 1868 онд Английн өмгөөлөгч Генри Друп шинэ КВОТ гаргасан. Энэ КВОТ нь мандатын тоон дээр нэгийг нэмээд хариуг нийт саналын тоонд хуваагаад гарсан хариун дээр нэгийг нэмсэнтэй тэнцэнэ гэж үзсэн. Энэ аргачлалаар КВОТ-ыг тогтооход арай илүү суудал шууд хуваарилагдах магадлалтай.

3. 1888 онд Бельгийн Их сургуулийн профессор Эдуард Гогенбах-Бишоф гэгч КВОТ нь мандатын тоон дээр нэгийг нэмээд хариуг нийт саналын тоонд хуваасантай тэнцэнэ гэж үзжээ. Эдгээрээс 2, 3 дахь арга нь Томас Хэрийн аргыг бодвол арай олон суудал шууд хуваарилагдах магадлалтай байдаг онцлогоороо давуу.

Зарим оронд нийт саналаа КВОТ тогтоолгүйгээр шууд дэс тоо буюу сондгой тоонд хуваах замаар суудлаа хуваарилдаг байна. 1889 онд профессор Виктор Ходт нийт саналаа дэс тоонд хуваах саналыг, Италийн судлаач Импералли дээрхтэй адил боловч хоёроос эхлэх саналыг, Францын эрдэмтэн А.Сент-Лагюе

<sup>14</sup>Ж.Бямбадорж. Сонгууль, сонгуулийн тогтолцоо, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал /I товхимол/ УБ., 1999 он.

1910 онд сондгой тоонд хуваах аргыг тус тус санал болгожээ. КВОТ-ыг улсын хэмжээний нийт саналд мандатын тоог харгалзуулан гаргахын зэрэгцээ зөвхөн тухайн тойргийн санал ба мандатыг харьцуулан гаргаж болно. Гэвч энэ нь тэгш байдлын зарчмыг алдагдуулж болно.

Хувь тэнцүүлэн сонгох аргаар сонгууль явуулахад бие даан нэр дэвшсэн сонгогдогч сонгуулийн КВОТ-оос дээш санал авбал сонгогдоно гэсэн үг юм. Хэрвээ нам, эвсэл нийт саналын тодорхой хувийг аваагүй бол түүнийг суудал хуваарилалтад оруулдаггүй бөгөөд энэ нь улс орны амьдралд нөлөө багатай жижиг намуудыг Парламентад оруулахгүй байх зорилготой юм. Жишээ нь: Германд 5%, Болгар, Унгар, Италид 4%, Израильд 1%, Египетэд 8% гэх мэтээр босго тогтоодог байна.

*Энэ системийн эерэг тал нь:*

- Улс төрийн хүчний харьцааг Парламентад зөв тусгах
- Санал болгон төлөөлөгдөх боломжтой
- Парламентын гишүүд улс төрийн намын өмнө хариуцлага хүлээх чадвартай байх
- Улс төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, түүний хариуцлага хүлээх чадварыг дээшлүүлэх боломж ихтэй.

*Сул тал нь:*

- Парламентад хэт олон нам төлөөлөгдөх магадлалтай. Ингэснээр Засгийн газрын бүрдүүлэлтэд хүндрэл учруулж зөвшилцөлд хүрэх боломж хязгаарлагдана.
- Бие даан нэр дэвшигч сонгогдох боломж хязгаарлагдмал.
- Орон нутгийн төлөөллийг хангах чадвар сул байна.

*Сонгуулийн холимог арга* нь олонхын саналаар сонгох болон хувь тэнцүүлэн сонгох аргын аль аль нь сайн муу талтайгаас зарим улс орнууд өөрийн онцлогт тохирсон аргаар сонгууль явуулахыг хэлнэ. Тухайлбал: ХБНГУ-ын Бундестагийн депутатуудын талыг нь 1 мандаттай тойрогт олонхын саналаар, талыг нь муж улсаас хувь тэнцүүлэн сонгох аргаар сонгодог байна. Энэ аргыг ихэвчлэн 2 танхимтай парламент бүхий улсууд хэрэглэдэг.

Холимог тогтолцоо нь 2 хувилбараар хэрэгждэг. Үүнд:

1. Мажоритар системийг голлон хэрэглэж пропорционалийг нэмэлт байдлаар ашигладаг. Жишээ нь: Мексикт 1 мандаттай тойргоор доод танхимын 300 депутатыг мажоритар системийн харьцангуй олонхын аргачлалаар сонгох, 100 депутатыг пропорциональ системээр олон мандаттай тойргоор нэмж сонгодог.

2. Парламентын тал хувийг мажоритар, тал хувийг пропорциональ системээр сонгодог.

Манай улсын хувьд 2012 оны УИХ-ын сонгуулийг холимог системээр явуулсан. Тус сонгуулиар 28 суудлыг намын жагсаалтаар, 48 суудлыг нэрсийн жагсаалтаар сонгогдож байжээ. Харин 2016 онд Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж сонгуулийн мажоритар системээр сонгууль явуулсан. 2019 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хуулиар Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгохоор зохицуулсан.

## **2.4. Сонгууль явуулах журам**

Ардчилсан нийгэмд ард иргэдээс төртэй харилцах гол суваг нь сонгууль байдаг. Өөрөөр хэлбэл сонгууль нь иргэд төрийг удирдах хэрэгт шууд буюу төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох боломж олгодог бөгөөд иргэдийн энэхүү эрхийг хууль, эрх зүйн хувьд баталгаажуулж өгөх нь онцгой ач холбогдолтой.

Монгол Улсад иргэдийн дээрх эрхийг дан ганц Үндсэн хуульдаа хуульчлан зааж өгөөд зогсохгүй, төрийн эрх барих дээд байгууллагын төлөөлөгчдийг сонгох,

түүнд сонгогдох эрхийг нь хангахад чиглэгдсэн Сонгуулийн тухай<sup>15</sup>, Монгол Улсы Их Хурлын сонгуулийн тухай<sup>16</sup>, Ард нийтийн санал асуулгын тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль<sup>17</sup>, Сонгуулийн автоматжуулсан системийн<sup>18</sup> тухай болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,<sup>19</sup> Сонгуулийн Ерөнхий Хорооноос гаргасан бусад шийдвэр зэргийг батлан гаргаж, сонгуулийн үйл ажиллагааг зохицуулж байна. Дээрх хууль, эрх зүйн актууд нь сонгууль явуулахад шаардагдах объектив болон субъектив үндэслэлийг бүрэн хангасан байх нь нэн чухал.

Сонгууль явуулах субъектив үндэслэл нь сонгуульд оролцогчдын сонгох ба сонгогдох эрхийг хангасан байх явдал байдаг бол объектив үндэслэл нь сонгуулийн үйл ажиллагааны хуульчлан тодорхойлогдсон журам юм.

Сонгуулийн үйл ажиллагаа нь нарийн дэс дараалалтай, тодорхой хугацаатай үйл явц байх бөгөөд түүний тодорхой үе шатуудад хийгдэх ажиллагаа, холбогдох байгууллага, албан тушаалтан, тэдгээрийн гүйцэтгэх ажил үүрэг, хугацаа зэрэг нь дээр дурдсан хуулиудаар нарийвчлан тогтоогдсон байна. Үүнд:

- Сонгуулийг товлон зарлах.
- Сонгуулийн тойрог, хэсэг, хороод байгуулах.
- Сонгогчдыг бүртгэх, нэрсийн жагсаалт гаргах.
- Нэр дэвшүүлэх.
- Ухуулга, сурталчилгаа явуулах.
- Санал хураах.
- Саналын хуудсыг тоолж, дүн гаргах.
- Шаардлагатай бол дахин санал хураах буюу дахин сонгууль зарлах
- Сонгуулийн эцсийн дүнг нэгтгэн гаргаж холбогдох этгээдэд хүргүүлэх гэсэн үе шатыг дамжина.

Сонгуулийн үйл явц, үр дүнтэй холбогдсон маргаан үүсвэл, түүнийг хуульд зааснаар Сонгуулийн төв байгууллага шийдвэрлэх бөгөөд түүний шийдвэрийг хууль бус гэж үзвэл Үндсэн хуулийн Цэцэд хандан маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулна.<sup>20</sup>

Сонгуулийн төв байгууллага нь Сонгуулийн ерөнхий хороо мөн бөгөөд энэ нь Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Ард нийтийн санал асуулгыг улсын хэмжээгээр эрхлэн зохион байгуулах чиг үүрэгтэй, үйл ажиллагаагаа бие дааж, хамтын удирдлагын зарчмаар явуулдаг байнгын ажиллагаатай төрийн байгууллага юм.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлыг хангахад сонгуулийн ерөнхий хороо нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

Тус хороо нь анх Улсын Бага Хурлын 1992 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 18 дугаар тогтоолоор тус Хороог 15 гишүүнтэй байгуулсан бол 2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Улсын Их Хурлын 31, 33 дугаар тогтоолоор тус Хороог 9 гишүүнтэйгээр шинэчлэн байгуулжээ.

Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно. “Төрийн албаны тухай” хуульд зааснаар Хорооны дарга, нарийн бичгийн дарга, төрийн тусгай албан тушаалын, Хорооны Ажлын албаны

<sup>15</sup>Төрийн мэдээлэл. УБ., 2016, №4

<sup>16</sup><https://www.legalinfo.mn/law/details/14869?lawid=14869>

<sup>17</sup> <http://legalinfo.mn/law/details/459?lawid=459>

<sup>18</sup>Төрийн мэдээлэл. УБ., 2011, №48

<sup>19</sup><http://legalinfo.mn/law/details/343?lawid=343>

<sup>20</sup> [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)

ажилтнууд төрийн захиргааны албан тушаалын ангилалд хамаарч ажилладаг бөгөөд "Төрийн албаны тухай", "Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай" хуулийн дагуу тэд дээрх албан тушаалд байх хугацаандаа намын гишүүнээс түдгэлздэг.

Сонгуулийн ерөнхий хороо анх байгуулагдсан цагаасаа хойш Монгол Улсын Их Хурлын сонгуулийг 7 удаа, Ерөнхийлөгчийн сонгуулийг 6 удаа эрхлэн зохион байгуулж, дүнг нэгтгэн Улсын Их Хуралд тайлагнаж, Орон нутгийн Хурлын 7 удаагийн сонгуулийг бэлтгэн явуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажилласан байна. УИХ-аас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийг батлан түүний эрх зүйн байдлыг тусгайлан хуульчилж өгсөн.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ

Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна. Сонгуулийн тухай хуулийн Улсын Их Хурлын сонгуулийн харилцааг зохицуулж байгаа зохицуулалтуудаас гадна дараах онцлог бүхий нэмэлт зохицуулалтуудыг тусгасан. Үүнд:

**3.1. Хуулийн Нэгдүгээр бүлэгт** хуулийн зорилт, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж, нэр томьёо, сонгуулийн төрөл, хэлбэр, үндсэн зарчим, сонгууль товлон зарлах, сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаатай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд дараах онцлог өөрчлөлтүүдийг тусгасан.

- Улсын Их Хурал ээлжит сонгуулийг товлон зарлах болон санал авах өдрийг хамтад нь тогтоохоор тусгасан,
- Сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд оролцдог төрийн байгууллагуудын сонгуулийн үйл ажиллагаатай холбогдон гарах улсын төсвөөс санхүүжих зардлаа тухайн жилийн төсөвтөө тусган батлуулдаг байхаар тусгасан,
- Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлээс гадна төлөвлөлт, зарцуулалтад аудитын байгууллага хяналт тавьж, дүгнэлт гаргана,

Сонгуулийн зардал, зардлын дээд хэмжээг тогтоох, сонгуулийн зардлын зарцуулалт, түүнд тавигдах хяналт, тайлан гаргахтай холбоотой харилцааг **Хуулийн Наймдугаар бүлэгт** нарийвчлан зохицуулж:

- Сонгуулийн зардлын гүйцэтгэлт тавигдах хяналтыг илүү сайжруулах, үр дүнтэй болгох талаар төрийн аудитын байгууллагын эрх хэмжээг тодорхойлсон,
- Зардлын тайланг түүнд хяналт тавих, нийтэд мэдээлэх эрх бүхий төрийн аудитын байгууллагад хүргүүлдэг байхаар тусгасан,
- Сонгуулийн зардал тэр дундаа хандивын хэмжээ, түүнийг хуулийн этгээд тайландаа тусгасан байдалд тавих хяналтын хувьд татварын байгууллагын оролцоог тодорхой болгон тусгасан.

*Сонгуулийг товлон зарлах:*

<b>Ээлжит сонгууль (өөрчилсөн)</b>	Улсын Их Хурал ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно. Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь тухайн сонгуулийн жилийн зургадугаар сарын сүүлийн хагасын аль нэг
------------------------------------	--



	ажлын өдөр байна.
<i>Шинээр оруулсан</i>	Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсны улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй болсон бол Улсын Их Хурал ээлжит сонгуулийг хойшлуулж болох ба сонгууль товлон зарласны дараа энэ онцгой нөхцөл бий болсон тохиолдолд Улсын Их Хурал ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зогсоож болно. Сонгуулийг хойшлуулсан эсвэл зогсоосон бол онцгой нөхцөл арилсны дараа ажлын долоон өдөрт багтаан, санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө ээлжит сонгуулийг товлон зарлана. Товлон зарлаагүй бол ажлын долоо өдрийн дараагийн өдрийг сонгууль товлон зарласан өдөрт тооцож, сонгуулийг зохион байгуулна.
<i>Ээлжит бус сонгууль (өөрчилсэн)</i>	Улсын Их Хурал ээлжит бус сонгуулийг санал авах өдрийн хамт санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө ээлжит бус сонгууль явуулах нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын 10 өдрийн дотор товлон зарлана.
<i>Нөхөн сонгууль (өөрчилсэн)</i>	Улсын Их Хурал нөхөн сонгуулийг санал авах өдрийн хамт санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө нөхөн сонгууль явуулах нөхцөл байдал үүссэнээс хойш 50 хоногийн дотор энэ хуульд нийцүүлэн товлон зарлана.

**Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа:**

<i>Өмнө байсан зохицуулалт</i>	10.1.Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:
	10.2.Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:
	10.3.Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:
<i>Шинээр оруулсан зохицуулалт</i>	10.4.Төрийн аудитын дээд байгууллага, онцгой байдлын, тагнуулын, төрийн тусгай хамгаалалтын, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаатай холбогдон гарах улсын төсвөөс санхүүжих зардлаа тухайн жилийн төсөвтөө тусган батлуулсан байна.
	10.5.Сонгууль зохион байгуулахтай холбоотой нэмэлт зардал шаардлагатай тохиолдолд Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Төсвийн тухай хуульд нийцүүлэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.
	10.6.Ээлжит бус болон нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан байгууллагын зардлыг Улсын Их Хурал тухай бүрд нь баталж улсын төсвөөс санхүүжүүлнэ.
	10.7.Ээлжит бус болон нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.6-д заасан зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргана.
	10.8.Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавин, аудит хийж, дүгнэлт гаргана. зардлын зарцуулалт, гүйцэтгэлийн тайланг ээлжит сонгуулийн

	жилийн 10 дугаар сарын 15-ны дотор, ээлжит бус нөхөн сонгуулийн тухайд санал хураалт дууссан өдрөөс хойш 90 хоногийн дотор тус тус гаргаж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.
--	--

**3.2. Хуулийн Хоёрдугаарт бүлэгт** Сонгуулийн нутаг дэвсгэрийн хуваарь, сонгуулийн тойрог, хэсэг түүнийг байгуулахтай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд дараах онцлог өөрчлөлтүүдийг тусгасан.

- Монгол Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн сонгуулийн тойргийг байгуулж, тойрогт нэгдэх мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно.
- Нэг хэсэгт байх сонгогчийн доод хязгаарыг тогтоосон
- Сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах ажиллагаа дуустал засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийн бүтэц, нэр, дугаарт өөрчлөлт оруулахыг хориглосон.

Тойрог байгуулах	Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн тойргийг аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно.
Хэсэг байгуулах	Сонгогчдын санал авч, тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид сонгуулийн хэсгийг ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарлана.
Сонгогчийн доод хязгаар	Хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төв болон дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байх бөгөөд нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна. Баг, хороог бусад баг, хороотой нийлүүлж хэсэг байгуулахыг хориглох бөгөөд сонгогчдын тооноос хамааран баг, хороог хувааж хэсэг байгуулж болно. Хэсгийн сонгогчдыг онцгой нөхцөл байдлын улмаас зохион байгуулалттайгаар тухайн хэсгээс тусгаарлах, хэсгийг нэгтгэх, шинээр байгуулах асуудлыг санал авах өдрөөс 35-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрлөөр шийдвэрлэж болно.
Хэсгийн мэдээлэл өгөх	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид сонгуулийн хэсгийг байгуулсан өдрөөс хойш тав хоногийн дотор сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэр, төвийг улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлнэ. Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс уг мэдээллийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нэгтгэн тав хоногийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.
Хязгаарлалт	Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийн бүтэц, нэр, дугаарт өөрчлөлт оруулахыг хориглоно. Ээлжит сонгуулиар байгуулагдсан хэсгийг энэ хуульд зааснаас бусад тохиолдолд дараагийн ээлжит сонгууль хүртэл өөрчлөхгүй.

**3.3. Хуулийн Дөрөвдүгээр бүлэгт** сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол шийдвэрлэх журам, харьяалал, сонгогч шилжихтэй холбоотой харилцааг зохицуулах бөгөөд дараах онцлог зохицуулалтыг тусгасан.

- Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжилсэн ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалтыг нэмж тусгасан,
- Итгэмжлэгдсэн ажилтан нь иргэний бүртгэлийн холбогдох байгууллагын сургалтад хамрагдсан төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч байхаар тусгасан.

*Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх.* Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэх бөгөөд тухайн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэл бүхий сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, нас, хүйс, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг гэсэн дарааллаар бичнэ.

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор болон хэсэг нэг бүрээр нэгтгэн гаргах бөгөөд уг жагсаалтыг ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, сонгууль дуустал өөрийн цахим хуудсанд байршуулна. Сонгогчдын нэрийн жагсаалт цаасан болон цахим хэлбэртэй байх бөгөөд сонгогчийг сонгуулийн зөвхөн нэг хэсэгт бүртгэнэ.

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах байгууллагуудаас гаргуулсан мэдээлэлд үндэслэн тухайн сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалтаас хасалгүйгээр “Тайлбар” хэсэгт “Түр хасав” гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийж, сонгогчдын тоонд оруулан тооцохгүй. Үүнд:

- эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон сонгуулийн насны иргэдийн мэдээллийг Улсын дээд шүүх
- хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан, захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа болон зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
- 60 түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэдийн мэдээллийг Улсын хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
- зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг цагдаагийн төв байгууллага
- тухайн жилд Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, харьяатаас гарсан иргэдийн мэдээллийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус ээлжит сонгуулийн жилийн 05 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Түүнчлэн Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн хамаарч байгаа сонгуулийн хэсэгт саналаа өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн сонгогчийг нэмж бүртгэн байнга оршин суугаа газрынх нь хаягийн дагуу бүртгэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасна. Үүнд:

- тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр харьяа тусгай анги, салбарт нь алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг Улсын хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

- тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр зэвсэгт хүчний цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч тухайн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч, дотоодын цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг цагдаагийн төв байгууллага тус тус ээлжит сонгуулийн жилийн 05 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг тусган уг жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ. Үүнд:

- сонгогчоос сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн талаар гаргасан гомдлын дагуу оруулсан өөрчлөлт;
- шилжилт, хөдөлгөөн зогсоохоос өмнө хийгдсэн сонгогчийн байнга оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт;
- сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс, регистрийн дугаар зэрэг иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт;
- нас барсан иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт;
- нэрийн жагсаалтаас түр хасагдсан, нэмэгдсэн, хасагдсан иргэдийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлт.

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хэсгийн хороо сонгогчдыг өөрт нь холбогдох мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломж олгох ба сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шалгасан байвал зохино.

<p>Ээлжит бус, нөхөн сонгуулийн сонгогчийн бүртгэл</p>	<p>Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог үндэслэн хэсгийг ээлжит бус, нөхөн сонгууль товлон зарласнаас хойш 20 хоногийн дотор байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарлана.</p>
<p>Итгэмжлэгдсэн ажилтан</p>	<p>Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтыг ээлжит бус, нөхөн сонгууль товлон зарласнаас хойш 50 хоногийн дараагаас эхлэн сонгууль дуустал өөрийн цахим хуудаст байршуулна Санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө холбогдох байгууллагууд түр хасагдсан, нэмэгдсэн, хасагдсан мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ</p> <p>Итгэмжлэгдсэн ажилтан улсын бүртгэлийн байгууллагын сургалтад хамрагдсан, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч байна. Итгэмжлэгдсэн ажилтан холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцын баталгаа гаргаж сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хороонд хүргүүлсэн өдрөөс эхлэн ажиллана.</p> <p>Итгэмжлэгдсэн ажилтан сонгогчдын нэрийн жагсаалтын цаасан</p>

	болон цахим хувилбартай танилцах, өөрчлөлт оруулах, сонгогчийн бүртгэлийг тулган шалгах, санал авах өдөр сонгогчдыг бүртгэх, таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжийг хариуцан ажиллана.
Сонсогчийн бүртгэлтэй холбоотой гомдол шийдвэрлэх журам	Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн бол өөрийн болон гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө сонгогчдын нэрийн жагсаалтад оруулна. Итгэмжлэгдсэн ажилтан сонгогчдын нэрийн жагсаалтад “Түр хасав” гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн иргэний сонгогчдын нэрийн жагсаалтад нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн шалтгаан арилсан тохиолдолд тухайн сонгогчийн өөрийнх нь хүсэлт, үндэсний гадаад паспорт, холбогдох нотлох баримтыг үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалт дахь зохих тэмдэглэгээг хүчингүй болгож, тухайн сонгогчийн бүртгэлийг сэргээн, энэ тухай тэмдэглэл үйлдэн хэсгийн хороонд мэдэгдэнэ.
Шилжих	Сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байгаа цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шийдвэрлэнэ. Нэр дэвшигч болон менежер, шадар туслагч нь сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих бол санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг хийлгэж болно.
Иргэний шилжилт, хөдөлгөөнийг зогсоох	Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол уг шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн өдрийн дараах ажлын өдрөөс эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ. Нэмэлт болон дахин санал хураалт явагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг түр зогсоох хугацааг тухайн нэмэлт болон дахин санал хураалт явагдаж дуустал үргэлжлүүлж, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ. Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох, сэргээх тухай шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.

**3.4. Хуулийн Тавдугаар болон Зургаадугаар бүлэгт** Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх нийтлэг журам, нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх, нэр дэвшигч болон нам, эвслийг бүртгэх, бүртгэхээс татгалзах үндэслэл, намын сонгууль эрхэлсэн байгууллагын эрх зүйн байдал, нэр

дэвшигчийн үйл ажиллагааны баталгаатай холбоотой харилцааг зохицуулсан.

Шинэлэг зохицуулалт нь:

- Сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын Дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй байхаар тусгасан,
- Нам, эвсэл сонгуульд оролцохоо ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд уг намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайланг ирүүлэхээр тусгасан.
- Нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал Засгийн газраас байгуулсан хамтын удирдлагын байгууллагын орон тооны болон орон тооны бус гишүүн ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 1 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөх, дахин сонгуулийн тухайд энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн байхаар тусгасан.

*Нам, эвсэл сонгуульд оролцох.* Нам, эвсэл сонгуульд оролцох хүсэлтээ санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлэх ба хүсэлтэд нам, эвслийн дарга гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ даран баталгаажуулан дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- Сонгуульд оролцох тухай намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын шийдвэр
- Намын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Намын улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн Улсын дээд шүүхээр баталгаажуулсан хуулбар
- Сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүний эдийн засгийн тооцоонд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт
- Нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх намын дотоод журам
- Ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд уг намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан
- Намын сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний тоо зэргийг агуулсан мэдээлэл
- Намыг төлөөлж Сонгуулийн ерөнхий хороотой харилцах гурван хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүн тус бүрийн харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг.

Эвслийн хувьд эвссэн бүх намууд хүсэлтэд тамга дарж баталгаажуулан дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- Сонгуульд оролцох тухай эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэр
- Эвсэлд нэгдсэн нам тус бүрийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Эвсэлд нэгдсэн нам тус бүрийн улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн Улсын дээд шүүхээр баталгаажуулсан хуулбар;
- Эвслийг төлөөлөх байгууллагаар батлагдсан сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүний эдийн засгийн тооцоонд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт
- Нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх эвслийн дотоод журам

- Ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд уг намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан
- Эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний тоо зэргийг агуулсан мэдээлэл
- Эвслийг төлөөлж Сонгуулийн ерөнхий хороотой харилцах гурван хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг
- Эвслийн гэрээний хуулбар
- Эвсэл байгуулах тухай нам тус бүрийн шийдвэр.

Сонгуулийн Ерөнхий хороо дараах шаардлагыг хангасан нам, эвслийг бүртгэж батламж олгоно.

- Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн
- Сонгуульд оролцох хүсэлтийг хуульд заасан хугацаанд ирүүлсэн
- Сонгуульд оролцох хүсэлтэд хавсарган ирүүлэх баримт бичиг бүрэн гүйцэд
- Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуульд заасан шаардлага хангасан тухай төрийн аудитын байгууллагын дүгнэлт гарсан
- Эвсэл байгуулах тухай энэ хуульд заасан журам, шаардлагыг хангасан
- Эвсэлд нэгдэн орсон намуудын олонх нь бүртгэсэн тухай шийдвэр гарахаас өмнө энэ хуульд заасны дагуу эвслээс гарахаа илэрхийлээгүй зэрэг.

Харин сонгуульд оролцох хүсэлтэд хавсарган ирүүлэх баримт бичиг дутуу бол бүртгэхээс татгалзана.

*Нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх.* Харин таван нас хүрсэн, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй. Санал авах өдрөөс 45 хоногийн өмнө нам, эвсэл нэр дэвшүүлэх, бие даан нэр дэвшүүлэх ажиллагааг эхлүүлж, 7 хоногийн дотор дуусгана.

Нэр дэвшигч хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

- Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх
- Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх.

Нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албаны, төрийн үйлчилгээний албаны удирдах албаны, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирлын албан тушаал эрхэлж байгаа бол ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.

Харин гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн болон авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.

Нам, эвсэл сонгуульд 76-аас илүүгүй хүнийг нэр дэвшүүлэх ба тухайн намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага хуралдаанаараа хэлэлцэж, нууцаар санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ.

Нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна. Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ тухайн тойрогт ногдсон мандатын тооноос илүүгүй хүнийг нэрийг дэвшүүлнэ.

Бие даан нэр дэвшүүлэхэд Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан тэмдэг дарж баталгаажуулсан маягтыг нэр дэвшүүлэх ажиллагаа явагдаж эхэлсэн үеэс авч, тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна. Сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байна.

Нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хороо бүртгэж, үнэмлэх олгоно. Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт багтаан дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ. Үүнд:

- Нэр дэвшүүлсэн тухай хуралдааны шийдвэр, нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт
- Нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл
- Хуульд заасан албан тушаалтан бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар
- Нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх Улсын дээд шүүхийн лавлагаа
- Нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт
- Нэр дэвшигчийн намтар
- Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар
- Ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа
- Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.

Бие даан нэрээ дэвшүүлэгч нь бие даан нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт багтаан дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ. Үүнд:

- нэрээ дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдэл
- сонгогчдын гарын үсэг зуруулсан маягт
- нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг
- Хуульд заасан албан тушаалтан бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар
- Нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх Улсын дээд шүүхийн лавлагаа
- Нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт
- Нэр дэвшигчийн намтар
- Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар
- бие даан нэр дэвшигчийг төлөөлж сонгуулийн төв байгууллагатай харилцах хоёр хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хүн тус бүрийн харилцах утасны дугаар
- төрийн аудитын дээд байгууллагаар хянуулсан бие даан нэрээ дэвшүүлэгчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлт
- Ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа



- Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа

Нэр дэвшигч нэр дэвшүүлэх ажиллагаа дууссанаас хойш гурав хоногт багтаан нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгээ өмнө нь мэдүүлж байгаагүй бол Авлигатай тэмцэх газарт мэдүүлнэ. Авлигатай тэмцэх газар нь нийт нэр дэвшигчид хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлсэн эсэх талаарх лавлагааг хугацаа дууссанаас хойш нэг хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ. Мэдүүлгийг өрийн байгууллагын цахим мэдээллийн сүлжээнд нээлттэй байршуулна.

Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авахдаа бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгах ба хэрэв баримт бичгийн бүрдэл дутуу бол хуульд заасан хугацаанд багтаан нөхөн ирүүлж болно.

Бие даан нэр дэвшигчийн цуглуулсан сонгогчдын гарын үсэг үнэн зөв эсэхийг түүвэрлэн тулгах, тухайн иргэнтэй уулзан нягтлан шалгаж болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг ажлыг аймаг, дүүргийн сонгуулийн хороогоор гүйцэтгүүлж болно.

Мөн нэр дэвшигчийн талаарх лавлагааг шаардлагатай гэж үзвэл эрх бүхий этгээдээс гаргуулан авах ба эрх бүхий этгээд тогтоосон хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэж тогтоол гаргана. Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл байхгүй бол нэр дэвшигч тус бүрд нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнө нэг өдөр олгож нийтэд мэдээлнэ. Нэр дэвшигчээр бүртгэх шийдвэр гарсан бол нэр дэвшигчээс татгалзахыг хориглоно.

Дараах тохиолдолд нэр дэвшигчийг *бүртгэхээс татгалзана*. Үүнд:

- хуульд заасан хугацаанд нэр дэвшүүлэх ажиллагааг явуулаагүй
- нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй
- өөр намын гишүүнийг нэр дэвшүүлсэн
- нэр дэвшигчээр бүртгүүлэхэд шаардагдах хуульд заасан баримт бичиг дутуу
- нэр дэвшигчээр бүртгүүлэхэд шаардагдах хуульд заасан баримт бичиг хуурамч болохыг шүүх тогтоосон
- нэгээс илүү тойрогт нэр дэвшсэн
- сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдөр дууса хүртэл хугацаанд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан болох нь тогтоогдсон
- Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, ийм агуулга бүхий мэдээллийг хэвлэмэл материалын хэлбэрээр, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараасан болох нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон;
- Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцээгүй

Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд нам, эвсэл санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин бүртгүүлэхээр шаардагдах баримт бичгийг сонгуулийн төв байгууллагад ирүүлнэ. Сонгуулийн ерөнхий хороо дахин бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч, санал авах өдрөөс 22 хоногийн өмнө бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан, нэр дэвшигч нас барсан, нэр дэвшигч шүүхээр ял шийтгүүлсэн тохиолдолд санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлж болох бөгөөд Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 22 хоногийн өмнө бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

Нэр дэвшигч дараах баталгаагаар хангагдана.

- Нэр дэвшигч өөрт шаардлагатай мэдээлэл, лавлагаа авах эрх эдэлнэ.
- Нэр дэвшигчийг зөрчил болон гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл хэргийн болон зөрчлийн газарт нотлох баримттай нь баривчилснаас бусад тохиолдолд Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх дараах ажиллагаа явуулахыг хориглоно.
  - Эрүүгийн хариуцлагад татах буюу эрүүгийн хэрэг үүсгэх, баривчлах, саатуулах, албадан саатуулах, цагдан хорих
  - орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийх.
- Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглоно.

**3.5. Хуулийн Долоодугаар бүлэгт** Сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаатай холбоотой харилцааг зохицуулсан.

- Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг төрийн аудитын байгууллагад хянуулах хугацаа, журмыг тодорхойлсон.
- Сонгуулийн сурталчилгаа явуулахдаа цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, уг харилцааг нарийвчилсан зохицуулалтыг тусгасан.
- Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны тоог үйл ажиллагааных нь цар хүрээтэй уялдуулан тогтоосон.
- Нийтийн эзэмшлийн гудамж талбайд үнэ, төлбөргүйгээр байршуулах зурагт самбарын тоо, хэмжээнд хязгаарлалт тогтоосон.

*Сонгуулийн мөрийн хөтөлбөр.* Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна.

Нам, эвслээс нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс өөр бие даасан сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байхыг хориглоно.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрт дараах зүйлийг тусгахыг хориглоно.

- Мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбоотой эрх олгох;
- Уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлого, түүнчлэн улс, орон нутгийн төсвөөс иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх;
- Зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх;
- Үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр үйлчилгээ иргэдэд үзүүлэх;
- Ажлын байранд зуучлах, ажилд оруулах;
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг иргэдэд тараан олгох, шууд зарцуулахтай холбогдсон асуудал;

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулсан байна.

Төрийн аудитын дээд байгууллага нам, эвслийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө, бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр хуульд

заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 33-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

*Сонгуулийн сурталчилгаа.* Улсын их хурлын гишүүнд нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс сонгуулийн сурталчилгааг эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно. Сонгуулийн сурталчилгааг дараах арга, хэлбэрээр явуулна. Үүнд:

- Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах
- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах
- Хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж талбайд байрлуулах
- Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх
- Ухуулах байр ажиллуулах
- Радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах
- Цахим хуудас ашиглах
- Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.

Сонгуулийн сурталчилгааны уулзалт, хандивын талаар сонгогчид зар, урилга явуулсныг сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалд оруулан тооцохгүй. Зар, урилга нь бичгийн А5 цаасны хэмжээнээс илүүгүй байна.

Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна. Радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдана.

Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- Мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх
- Нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх
- Сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах
- Ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх
- Хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах
- Сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах.

Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

- Хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх
- Зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх

- Сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах
- Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашиглах
- Оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах
- Олон нийтийг хамарсан аливаа шашны зан үйл ашиглах, түүнийг зохион байгуулах, оролцох, ивээн тэтгэх, шашны холбогдолтой эд зүйл тараах.

Түүнчлэн аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.

Нам, эвслийн дарга, түүнчлэн нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орохыг, түүнчлэн сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлэх, нийтлэхийг хориглоно.

Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигч болон түүний менежер, шадар туслагч, ухуулагчаас бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно.

**3.6. Хуулийн Есдүгээр бүлэгт** саналын хуудас түүнд тавигдах шаардлага, хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалахтай холбоотой харилцаа, санал авах байр хугацаа, зөөврийн болон санал авах байранд санал авах ажиллагаа, сонгуулийн ажиглах, санал хураалтын дүнг гаргах зэрэг үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан.

*Саналын хуудас нь* агуулга, бичилт, хэлбэрийн хувьд сонгогчоос саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой, сонгогч саналаа тэмдэглэх тухай заавар бүхий тусгай нууцлал, нэгдсэн дугаартай байна. Саналын хуудсанд нэр дэвшигчийн дарааллыг бичихдээ нам бол Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар, эвсэл бол тухайн эвсэлд нэгдсэн орсон намуудаас хамгийн түрүүнд Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намын дарааллаар, нам, эвслээс нэр дэвшигчийг тухайн нам, эвслээс ирүүлсэн дарааллаар, бие даан нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хороонд бүртгэсэн дарааллыг баримтлан нам, эвслээс нэр дэвшигчдийн нэрийн дараа гэсэн эрэмбээр бичнэ.

*Санал авах байр, хугацаа.* Сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07:00 цагаас 22:00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна.

Тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай дараах зүйлийг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэгтэй. Үүнд:

- санал авах байр
- сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг
- зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг аар санал өгөх сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг
- суурин болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг
- сонгогчийн бүртгэлийн мэдээллийг ажиглагчид үзүүлэх дэлгэц

- хууль тогтоомжид заасан бусад.

*Санал хураалтын дүн гаргах.* Мэдээллийн технологийн даамал санал авах ажиллагаа дуусмагц санал тоолох төхөөрөмжөөс дүнгийн хуудсыг шаардлагатай тоогоор хэвлэж, хэсгийн хороонд өгч, санал хураалтын дүнг хэсгийн хорооны ажиллагаанаас хамаарахгүйгээр Сонгуулийн ерөнхий хороонд нэн даруй дамжуулна.

Санал авах ажиллагааны хуулиар тогтоосон цаг дуусаагүй байхад санал тоолох төхөөрөмжөөс дүнгийн хуудсыг хэвлэж гаргах, санал хураалтын дүнг дамжуулахгүй байх, саатуулах, зогсоохыг хориглоно. Санал хураалтын дүнг дамжуулах үеийн хамгаалалтыг тухайн санал авах байрны хамгаалалтад ажиллаж байгаа цагдаагийн албан хаагч хариуцна.

Санал хураалтын дүнг гаргахтай холбоотой хэсгийн хороо дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

- хэсгийн хороо нь санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудсыг ажиглагч нарт өгч, дүн танилцуулсан тухай тэмдэглэл хөтлөх
- санал авах байранд болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгсөн сонгогчийн тоо нь санал авахад олгосон саналын хуудасны тоо, буруу тэмдэглэл хийснээс болон санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүйгээс буцааж хураагдсан саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, тооцоог эцэслэн гаргах
- санал авахад зарцуулсан болон зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн хэсгийн хорооны хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл шалтгааныг тогтоох бөгөөд шаардлагатай гэж үзвэл саналын хуудсыг нэн даруй дахин тоолж, тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд хэсгийн хорооны дарга, гишүүд гарын үсэг зурна
- нэмэлт санал хураалт явагдах нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд санал авахад зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудасны баруун доод өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэлд тусган боож, битүүмжлэх.

Санал авах ажиллагаа дууссаны дараа сум, дүүргийн сонгуулийн хороо харьяа бүх хэсгийн 50 хүртэл хувийг нь санамсаргүй сонголт /сугалах/-ын аргаар сонгож, хяналтын тооллого хийлгүүлнэ. Хяналтын тооллого хийхээр сонгогдсон хэсгийн хороо санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудсыг гар аргаар нэг бүрчлэн тоолно.

*Санал хураалтыг хүчингүйд тооцох.* Санал хураалтыг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд санал авсан, түүнчлэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авснаас бусад тохиолдолд санал авахаар зарласнаас өөр өдөр санал авсан нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр бол, саналын хуудас бүхий зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, санал авах журам зөрчсөн нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр бол хүчингүйд тооцно.

Энэ тохиолдолд санал авах ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороо хүчингүйд тооцож хүчингүйд тооцсон хэмжээгээр дахин санал хураалт явуулна. Дахин санал хураалт явуулах тухай шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргах бөгөөд шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор зохион байгуулж явуулна. Дахин санал хураалтад дараах сонгогчийг оролцуулна:

- хэсгийн хэмжээгээр хүчингүйд тооцсон бол хүчингүйд тооцсон тухайн хэсгийн нийт сонгогчийг;
- зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авсан саналыг хүчингүйд тооцсон бол уг саналын хайрцагт саналаа өгсөн сонгогчийг.

Сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөх гэдгийг санал хураалтын явцад гарсан зөрчил нь сонгуулийн дүнд илт нөлөөлөхүйц буюу сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигч ба түүний дараах нэр дэвшигчийн авсан саналын зөрүүтэй тэнцүү, эсхүл илүү байхыг ойлгоно.

Нэмэлт болон дахин санал хураалтын хугацаанд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглоно.

*Ээлжит бус сонгууль, нөхөн сонгууль, нэмэлт санал хураалт.* Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал өөрөө тарах шийдвэр гаргасан, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргасан тохиолдолд ээлжит бус сонгуулийг зохион байгуулж явуулна.

Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудлыг нөхөх зорилгоор нөхөн сонгууль явагдана. Орон гарсан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахад зургаан сар хүрэхгүй хугацаа үлдсэн бол орон гарсан суудлыг нөхөхгүй. Нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

Нэр дэвшигчдийг авсан саналын тоогоор нь жагсааж, мандатын тоогоор таслахад нэр дэвшигчдийн авсан саналын тоо тэнцсэний улмаас мандатад хуваарилагдах боломжгүй болсон бол тухайн тойрогт нэмэлт санал хураалт явуулна.

Сонгуулийн тойрогт хамаарах сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын тавь буюу түүнээс дээш хувь нь санал хураалтад оролцоогүй бол тавин хувь нь оролцоогүй хэсэг тус бүрд нэмэлт санал хураалт явуулна.

Нэмэлт санал хураалтад санал нь тэнцсэн нэр дэвшигчдийг оруулах бөгөөд эхний санал хураалтад оролцоогүй, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдыг нэмэлт санал хураалтад оролцуулна. Нэмэлт санал хураалтад оролцсон сонгогчдын ирц, саналын тоог эхний санал хураалтад оролцсон сонгогчдын ирц, саналын тоо дээр нэмж тооцно.

Нэмэлт санал хураалтад орсон нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан, үлдсэн мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ**

### **4.1. Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн зохицуулалт.**

Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харьяаллыг дараах байдлаар тогтоож өгсөн.

- Сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд нь тухайн гомдол, маргааны онцлог байдлыг харгалзан УИХ-ын сонгуулийн тухай хуульд өөрөөр заагаагүй бол тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ.
- Сонгуулийн хороод УИХ-ын сонгуулийн тухай хуульд заасны дагуу шатлан захирагдах зарчмаар ажиллах бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргана.

- Хуульд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.
- Үндсэн хуулийн цэцэд харьяалуулснаас бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

Сонгуулийн хороодын шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор өргөдөл, гомдол гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн гомдлыг хүлээн авахгүй.

Сонгогчид бэлэн мөнгө, эд зүйл тараасныг сонгогч баримттайгаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно. Сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон бол мэдээлэл гаргасан иргэн тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг гэм буруутай этгээдээс гаргуулахаар шаардах эрхтэй.

#### 4.2. Эрүүгийн хуулийн зохицуулалт<sup>21</sup>.

Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэсэн арван дөрөвдүгээр бүлгээр<sup>22</sup> зохицуулсан байна.

Объект	Субъект	Үйлдлийн шинж	Объектив шинж	Субъектив шинж	Оногдуулах ял
<b>14.5 дугаар зүйл. Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх гэмт хэрэг</b>					
Иргэний сонгох, сонгогдох эрх	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	Иргэний сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд Сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа үйл ажиллагаанд	Саад учруулсан	Зориуд (санаатай)	- дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр <b>торгох</b> - хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар <b>нийтэд тустай ажил хийлгэх</b> - нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар <b>зорчих эрхийг хязгаарлах</b> ялын аль нэгийг
<b>Хүндрүүлэх шинж</b>					
Иргэний сонгох, сонгогдох эрх	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	Дээрх гэмт хэргийг	Хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж Хууран мэхэлж Сонгогчийг эд хөрөнгө, мөнгөөр	Зориуд (санаатай)	- таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр <b>торгох</b> - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар <b>зорчих</b>

<sup>21</sup> С.Гантулга, Б.Энхболд., Эрүүгийн эрх зүй (тусгай анги) сурах бичиг, УБ, 2018, 103-110-р тал

<sup>22</sup> Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), Төрийн мэдээлэл, УБ, 2016, №7

			татаж санал худалдан авч үйлдсэн		<b>эрхийг хязгаарлах</b> - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар <b>хорих</b> ялын аль нэгийг
<b>14.6 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх гэмт хэрэг</b>					
Сонгууль явуулах талаар тогтоосон журам	18 насанд хүрсэн, сонгуулийн эрхтэй субъект	Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, ард нийтийн санал асуулгад	нэгээс илүү удаа санал өгсөн	Санаатай шинж	- дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр <b>торгох</b> - хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар <b>нийтэд тустай ажил хийлгэх</b> - нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар <b>зорчих эрхийг хязгаарлах</b> ялын аль нэгийг
	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна		нэгээс илүү удаа санал өгөхийг зохион байгуулсан		
Сонгууль явуулах талаар тогтоосон журам	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	Сонгуулийн саналын хуудас, ард нийтийн санал асуулгын хуудсыг	хууль бусаар бэлтгэсэн	Санаатай шинж	- таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр <b>торгох</b> - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар <b>зорчих эрхийг хязгаарлах</b> , - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар <b>хорих</b> ялын аль нэгийг
			хадгалсан		
			тээвэрлэсэн		
			ашигласан		
<b>14.7 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах гэмт хэрэг</b>					
Иргэний сонгох, сонгогдох эрх Сонгууль явуулах талаар тогтоосон журам	Сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулах хорооны дарга, гишүүн, эсхүл бусад албан тушаалтан	улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн талаар	сурталчилгаа явуулсан	Санаатай	- таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр <b>торгох</b> - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар <b>зорчих эрхийг хязгаарлах</b> - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар <b>хорих</b> ялын аль нэгийг
		сонгогчийн санал өгөх, санал хураах, тоолох ажилд	саад хийсэн	Зориуд (санаатай шинж)	
		бусдыг төлөөлж санал өгөх, саналын хайрцгийн лац, битүүмжлэлийг	гэмтээх, гарын үсэг хуурамчаар үйлдэх	Зориуд (санаатай шинж)	
		саналын хуудас	зохион	Санаатай	



		солих, хүчингүй саналын хуудсаар санал авахыг	байгуулсан хатгасан		
		санал хураалтын дүнг	дэмжсэн		
			өөрчилсөн		
<b>14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэрэг</b>					
Улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүнд, ажил хэргийн нэр хүнд, сонгууль явуулах журам	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж	илт худал мэдээлэл тараасан	Санаатай	- дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр <b>торгох</b> , - хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар <b>нийтэд тустай ажил хийлгэх</b> , - нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар <b>зорчих эрхийг хязгаарлах</b> ялын аль нэгийг
		<b>Хүндрүүлэх шинж</b>			
Улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүнд, ажил хэргийн нэр хүнд, сонгууль явуулах журам	Төрийн албан хаагч, сонгуулийн хорооны албан тушаалтан, ажилтан		Үйлдсэн	Санаатай	- нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар <b>нийтийн албанд томилогдох эрх хасаж</b> нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр <b>торгох</b> , - зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар <b>зорчих эрхийг хязгаарлах</b> , - зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар <b>хорих</b> ялын аль нэг
<b>14.9 дүгээр зүйл. Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах гэмт хэрэг</b>					
Сонгууль явуулах журам	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	Сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх зорилгоор Эрүүгийн хуулийн 14.5, 14.6, 14.7 дугаар	бэлтгэсэн зохион байгуулсан	Санаатай	- арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр <b>торгох</b> , - хоёр жилээс найман жил хүртэл

		зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхэд			хугацаагаар хорих ялын аль нэгийг
--	--	--	--	--	--------------------------------------

### 4.3. Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт.

Сонгуулийн зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг шийтгэлийн хэр хэмжээнээс хамааруулан 6 сараас 2 жил байхаар тогтоосон Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийг зохицуулалтыг баримтална.

Хуулийн этгээдийг төлөөлөн, түүний ашиг сонирхлын төлөө Зөрчлийн хуульд заасан зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан шийтгэл оногдуулна.

	Зөрчлийн шинж	Шийтгэл	Шалгах харьяалал
<b>17.1 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль зөрчих</b>			
1	Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах, сонгогчоос саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	- хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр <b>торгох</b> , эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар <b>баривчлах шийтгэл</b> ногдуулах, - хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасан - сонгуулийн хэсэг байгуулах журмыг зөрчсөн	хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
3	Сургалтад хамрагдаж, гэрчилгээ аваагүй төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийг сонгуулийн хороодод томилсон бол	- хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
4	Хүн, хуулийн этгээд нь сонгуулийн хорооноос мэдээлсэн санал хураалтын урьдчилсан дүнг илтэд гуйвуулсан, өөрөөр мэдээлсэн, мэдэгдэл хийсэн бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
5	Сонгуулийн ажилд туслалцаа үзүүлэх, эсхүл сонгуулийн хорооны ажиллах байр, санал авах байрыг үнэ төлбөргүй гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй бол	-хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
6	Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах үүргээ биелүүлээгүй бол	-хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч

7	Хуульд зааснаас бусад тохиолдолд сонгогчдын нэрийн жагсаалтыг олшруулсан, эсхүл тараасан бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч
8	Нэр дэвшигчээр бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш нэр дэвшигчээр бүртгэгдсэн этгээд нэр дэвшихээс татгалзсан бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
9	Бие даан нэр дэвшигчид нэгдэж сонгууль эрхэлсэн байгууллага байгуулсан бол	-хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
10	Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	-хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Эрүүгийн хэргийн шүүх
11	Сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол	-хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч
12	Сонгуулийн сурталчилгаанд тээврийн хэрэгсэл ашиглах журмыг зөрчсөн бол	-хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
13	Ухуулах хуудсыг байршуулахдаа цавуу, цавуулаг эд зүйл ашиглан тогтоож гудамж талбай, орчныг бохирдуулсан бол	-учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
14	Намын далбаа, уриа, таних тэмдгийг байрлуулахыг хориглосон газарт байрлуулсан бол	-хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
15	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах талаар хуулиар тогтоосон журам зөрчсөн бол	-хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
16	Сонгуулийн сурталчилгаанд хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, эсхүл бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол	-хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
17	Үүрэн холбооны болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч	-хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,	Мэргэжлийн хяналтын

	нь эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаагаагүй бол	хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	улсын байцаагч
18	Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол	-хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
19	<p>Хүн, хуулийн этгээд нь ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, эсхүл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал сонгогчдын саналыг татах зорилгоор:</p> <p>- бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдсан, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон төлбөргүйгээр үзүүлсэн бол</p> <p>-нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, хонжворт сугалаа зохион байгуулсан, ивээн тэтгэсэн бол</p> <p>-сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулсан, амралт, сувилалд амраасан, сувилуулсан бол</p> <p>-ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулсан, хэлцэл хийсэн бол</p> <p>-хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэргээр бусдад давуу байдал олгосон, амлалт өгсөн бол</p> <p>-сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулсан бол</p> <p>-харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн</p>	<p>-хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	<p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч</p> <p>Эрүүгийн хэргийн шүүх</p> <p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч</p>

	шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол		
20	Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээдээс бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийсэн бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Мэргэжлийн хяналтын улсын байцаагч
21	Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад: - хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулсан;		Эрүүгийн хэргийн шүүх
	-зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн бол		Эрүүгийн хэргийн шүүх
	-сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт өгсөн, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашигласан бол		Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
	-нам, эвслийн нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн мөрийн хөтөлбөрөөс тусдаа мөрийн хөтөлбөр гаргаж ашигласан бол		Эрүүгийн хэргийн шүүх
	-хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашигласан бол		Мэргэжлийн хяналтын улсын байцаагч
	-чанга яригч ашиглан оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд сонгуулийн сурталчилгаа явуулж, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан бол		Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
	аливаа шашны зан үйл ашигласан, түүнийг зохион байгуулсан, оролцсон, ивээн тэтгэсэн, шашны холбогдолтой эд зүйл тараасан бол		Цагдаагийн байгууллагын эрх бүхий

			алба хаагч
22	Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргасан, эсхүл гаргахгүй байхаар амлалт авсан, гэрээ байгуулсан бол	-хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч
23	Нам, эвслийн дарга, түүнчлэн нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад оролцсон, эсхүл сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн, нийтэлсэн бол	-хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Мэргэжлийн хяналтын улсын байцаагч
24	Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Татварын улсын байцаагч
25	Хуульд заасан хэмжээнээс хэтрүүлж нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид хандив өгсөн, эсхүл тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгсөн бол	-хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно	Татварын улсын байцаагч
26	Хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн хандивыг буцаан шилжүүлээгүй бол	-хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Эрүүгийн хэргийн шүүх
27	Мөнгөн бус хандив өгөх талаар хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол	-хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Татварын улсын байцаагч
28	Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч
29	Сонгуулийн зардлын данс байршуулсан банк сонгуулийн	-хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,	

	санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол	хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Монголбанкны хянан шалгагч
30	Нэр дэвшигч, нам, эвсэл хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол	-хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч
31	Сонгуулийн хуульд заасан итгэмжилсэн иргэн хоёроос дээш сонгогчид туслалцаа үзүүлсэн бол	-хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
32	Нэр дэвшигч, ажиглагч, улс төрийн албан тушаалтан итгэмжилсэн иргэний үүргийг гүйцэтгэсэн бол	-хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Татварын улсын байцаагч
33	Сонгогч нь: авах байрнаас саналын хуудас авч гарсан; саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн тэмдэглэсэн саналыг баримтжуулан зураг авсан, дүрс бичлэг хийсэн, шууд дамжуулсан, бусдад харуулсан; саналын хуудсанд зориулалтын бус үзгээр санал тэмдэглэсэн; аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар мөнгө, эд зүйл шаардсан, шаардаж авсан бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
34	Санал авах өдөр ажиллаж байгаа сонгогчийг санал өгөх боломжоор хангах үүргээ биелүүлээгүй бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
35	Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд болон ажиглагч нь сонгуулийн хорооны ажиллах байр болон санал авах байранд сонгуулийн сурталчилгаа, түүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулсан бол	-хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
36	Ажиглагч хуульд заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал мэдээлэл нийтэд тараах	-хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч

	зэрэг хууль бус арга хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	төгрөгөөр торгоно.	
37	Санал авах өдөр: согтууруулах ундаагаар үйлчилсэн, худалдан борлуулсан; олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан; гадаа болон битүү талбайд худалдаа, үйлчилгээний төв ажиллуулсан бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
38	Санал хураалтын дүн, сонгуулийн баримт бичгийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх, дамжуулахад саад учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Тагнуулын ерөнхий газар
39	Сонгуулийн автоматжуулсан системийг ашиглан явуулж байгаа мэдээллийн ажиллагаанд хуулиар эрх олгогдоогүй хүн, хуулийн этгээд хөндлөнгөөс оролцсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	-хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Тагнуулын ерөнхий газар

## ХУУЛИЙН ХЭЛТЭС